



**Б.БААСТ**

**ХАНГАЙН БОР**

**Б.Бааст**

# **Хангайн Бор**

[www.kiebooks.com](http://www.kiebooks.com)

## Нэг. Дэлт саарал

*Хүчин чадлаа барсан арслан,*

*эрх мэдлээ алдсан бүргэд,*

*ижил ханиасаа хагацсан тагтаа цөм л хүсэн мөрөөдсөөр үхдэг гэдэг билээ.*

**Э. Сетон-Томисон**

Хуучцуул, дэлт чоно бий гэнэ. Зүгээр ч үгүй хангайн нутагт дэлт чоно бий гэнэ. Харин дэлт чонын элбэг ховрын тухайд гэвэл өдрийн од шиг ховор үзэгддэг гэнэ. Дэлт чоныг үзсэн гэдэг анч гөрөөч нараас, тэр чоныхоо шинж төрөхийг өгүүлнэ үү гэхэд,

- Бие маш томтой. Жирийн чоно түүний дэргэд эхийнхээ хамт буй тугал л гэсэн үг гэнэ. Дэлт чоно цээж ханхгар, сээр өндөр, сэрвээн дээгүүрээ, хойшоо дарсан тожгор хар дээлтэй, мөн ч жирийн чоныг бодвол зогдортой ч юм шиг харагддаг гэнэ.

- Тэр чинь дол цохиж долоо шархадсан хөгшин азарган чоно бус уу? гэвэл,

- Насаараа хээрээр гэр хийж, хөх мөнгөн тэнгэр бүрхүүлийнхээ дор явдаг хүнээс тийм гэнэн томоогүй юм асууж юугаа хийнэ. Дэлт чоно жирийн чоно хоёрыг ялгахгүй бол анчин гэж сүр болсны ч хэрэггүй шүү дээ гэнэ.

- Жирийн чоно, дэлт чонын дэргэд ямар янз шинжтэй байдаг вэ? Гэвэл

- Ой, хангай чонын нуруун үсний үзүүр хар сортой, хэвлий нь нилээд цайвардуу, заримдаа шаргалдуу болоод хөх ноолууртай, жижгэвтэр жартгайдуу нүдтэй... Цас бороо, шороо нүүр нүдгүй харанхуйг далимлан малруу дайрна. Тийм дээрээс хэрээ шорооноор, чоно борооноор гэдэгүг гараа биз. За тэгээд идхээсээ сэглэх дуртай. Бөөн хонин дунд орсон бол хичнээн ч хамаагүйг хонины сүүл таслана. Хоолойг нь тас хазна. Шөнө малын хашаа давна. Малыг бөх баг бус саравчийг дээрээс нь цоолоод орсон үзэгдэнэ. Түүний жижиг үүдэн шүд, хурц том хоёр соёо, хатан төмөр шиг араа нь аймшигтай. Жирийн чоно дэлт чоныг бодвол хүчин чадал мөхөс учир өөрийнхөө дийлэхгүй гэсэн мал, адгуус гөрөөсийг нойтон газар, хад мөсөнд халтиргах, уулнаас нисгэх, ус намагт суулгах, ёроолгүй ганга жалагруу шахаж унагах зэргээр амин хорлож иднэ. Барьж аваачсан хурга ишгийг бэлтрэгээрээ ноцож ноолуулан тамий нь цайлгаж ан авд сургана гэнэ.

Зуны цагт дэлт чоно бараг үл үзэгдэнэ. Газар сайгүй өвс ногоо болчихоод мөр гарахгүй. Ер нь ч элс шавар мэт мөрний хээ хэв гарах газар тэр бүр гишгэхгүй. Өдрийн одыг хүн бүр хардаггүйн адил дэлт саарлыг тэр бүр хүн харж үл чадна. Анчид түүнийг харавч агнасан нь ер үгүй. Зарим нь ерөөсөө буудахыг ч үл хүснэ. Зарим нь буудах гээд буугаа шагайсанаа больсон нь ч бий. Яагаад вэ? гэвэл буудаад амин газры нь онохгүй, дэмий шархдуулж орхивол тэрнээсээ дор юм болж юу магад гэнэ. Ер нь тэрхүү дэлт чонын ов мэх, хүчин чадал маш их.

Санаа туйлын муу. Дэлт чоно үргэлж өлсгөлөн гуринх явавч малын аль шилдэг тарганыг иднэ. Түүний хэзээ малд хүрсэн, яаж мал унагасан нь үл үзэгдэнэ. Энд тэнд хүмүүсийн аль сайн мал чононд орсон сураг сонсогдоно. Тэгэхээр анчид, түүнийг "Нөгөө дэлт саарал гайхал л унагасан бий" гэлцэнэ. Дэлт чоныг унагасан хүнийг ёстой анчин хэмээн алдаршуулна. Түүнийг унагасан хүнд илүү урамшил шагнал өгнө гэж хүн бүрийн ярих үгийн өнгө ганцхан янз байх тул үнэхээр дэлт чоно хангайд байвч ганц нэгээс илүүгүй нь үнэн бололтой. Ховор амьтныг анчин хүн бүрэлгэх дургүй байдаг учир тэр дэлт чоно ганцхан ширхэг юм болохоор нь анчид буудахгүй байна гэж ярилцах нь бас сонсогдоно.

Өвлийн цагт дэлт чонын мөрийг анчид хааяагүй үзнэ. Бусад чонын мөрний дэргэд дэлт чонын мөр аяганы ам шиг том байна. Цасан дээр гишгээд 2 цаг болсон мөр бол зөөлөн, илчтэй юм шиг байдаг. Чухам тэр илчтэй юм шиг санагдах нь л муу эрийг айлгана. Цасан дээр мөр удах тусмаа хатуурч, бүр удвал цан талстууд ургана. Тэгээд хуучран баларна. Анчид дэлт саарлыг хангайн чонын ганц эзэн л гэнэ. Дэлт чонын бас нэг онцлог нь гагцхүү өөрийнхөө л барьсан малыг иднэ. Орооных нь үе болбол дэлт чоно байршил газрынхаа хад чулууны аль өндөр дээрээс, нурууныхаа үсийг өрвийлгөж байгаад урт гүн амьсгаа татуулан улина. Энэ нь "Цуглан ир! Хүрч ир!" гэсэн дохио юм. Дэлт чонын дууг тэр тойронд нь яваа сүрэг нь сонсоод хариу улина. Чоно ганцаараа тэнэвч нэгнийхээ дуу хүрэх газар явдаг гэдэг. Энэхүү хариу улилт нь нэгд, дэлт "Эзэндээ" "Бид одоо очлоо" гэж хариу дохиолсон хэрэг. Хоёрт, мөн өөрснөө цааш тэнэж яваадаа "цуглан ир" гэсэн дохио өгсөн хэрэг болно.

Тэр дохиог сонсоод "харьяа" гэж нутгийнхаа зах сэжүүрээр тэнэж явсан хэсэг нь хариу өгөн улина. Тэр нь "одоо очлоо" гэсэн хариу болно. Хэрэв зах хязгаар нутгаар золбирон тэнэж яваа хэсэг нь хариу өгч уливал түүнийг хүний гарт алагдаж үрэгдлээ гэж үзнэ. Орооны чоно ингэж цуглана. Эзэн чонын дуудлагаар ирэхгүй, сүүлд зарим чоно газрын хаанаас ч юм бэ тэнэж яваад хүрч ирвэл тэр чоно олныхоо хатуу залхаалт заавал үзнэ. Чоно орооныхоо бус цагт ийнхүү ганц нэгээр хаа дуртай газраа тэнэх боловч өөрийн нутгийн бүснээс үл гарна. Чононд хэрэв бусад амьтны адил өөрийн амь зуух бүс гэж байдаггүй бол өдийд зарим газар чонын үүр болж, тэнд чоно багтахыа байж зарим газар огт чоногүй болохсон бус уу! Харин ой модгүй буюу говь тал газар бол чонын байршилтын тухай өөр зүйл өгүүлж болно.

Дэлт чоно ч тэр, жирийн чоно ч тэр хангайд ийм бүс дотор оршдог атлаа цааш нь хөвчийн гүн рүү яагаад үл нэвтэрнэ вэ? гэж хашир анчдаас асуухад,

- Тэр бас учиртай гээд анчид ийн өгүүлнэ. Хүн ер нь эргэн тойрны газар нутаг байгаль ертөнц, тэнд орших араатан амьтны болон жигүүртний аж төрөх, амьдрахуй байдлыг нарийн сайн мэдүүштэй шүү. Хангай болон ой хөвчийг ан гөрөөс, араатан жигүүртэн цөм тун нарийн учиртай эзэмшиж өөр өөрийнхөөрөө гайхалтай аж төрнө шүү. Дэлт чоно жирийн чонын аль алин нь хөвчийн гүнд аж төрж үл болно. Яагаад вэ? гэвэл балар ширэнгэ, хүглэгэр их хөвчийн бүрэн эрх дархтай эзэд хэн бэ? Дэлт чоно, жирийн чоно тэдэнд халдан довтолбоос дийлэхгүй юу? гэвэл огт дийлэхгүй. Балар ширэнгэ хүглэгэр хөвчид баавгай, хавах бодон, манж хандгай зэрэг асар хүчтэн бий гэнэ.

- Хаван бодон гэгч нь ямар бодон бэ?

- Хаван бодон гэгч нь нас гүйцсэн хамгийн том бодон. Бодонгийн туйл ч гэж хүмүүс

хэлэлцэнэ. Соёо нь гэвэл ургаж туйлдаа хүрсэн бөгөөд тэр нь зөвхөн хоёр том соёо ч бишээ, ёстой л хоёр махигар ган хяргуур л гэсэн үг. Хаван бодонд зүрхлэн халдах хүчтэн алга. Хаван бодон орооныхоо үед бусад бодонтой үзэлцэх гэж мөс шавартай усанд дахин дахин хэвтэж, өөрийн биеийг давхар давхар мөс шавар чулуу шаргисан хуягаар хуяглана. Өөрийгөө ингэж ямар ч амьтан хазах хатгах аргагүй болтол хуягласан амьтанд хэн халдах юм бэ! Хаван бодон өөрийнхөө эзэмшил бүсэнд чоно орж ирсэн байвал мэгжүүдээ торойтой нь цуг чоноруу билчээгээд өөрсдөө нуугдаж гүйлдсээр чоныг бүслэн авна. Чоно ийм үедээ гагцхүү мэгж, торойг яаж барих вэ гэж бодно уу гэхээс бодонгууд ирж тасар хяргаж сүлбэнэ гэж яахин мэднэ ажээ. За ингээд чоно ч мэгж, торой луу довтолгоонд орно бодонгууд ч, чоно руу довтолгоонд орно. Гэнэдсэн чоно яаж ч чадахгүй бодонгийн соёонд хяргагдана. Амь зулбан зугтавч гарах газаргүй болно.

Хөвчийн хэсэг нутгийг гахай ингэж эзэгнэнэ. Хөвч тэр нутаг руу чоно ингээд нэвтэрч үл чадна. Гэтэл нутгийн бусад хэсгийг хангайн сүрэг эзэмшинэ. Хангайн сүргийн толгойлогч нь манж хандгай хэмээх асар хүчтэн билээ. Өөрийн эзэмшил газар руу чоно орж ирсэн үнэр үнэртмэгц манж хандгай чонотой тулалдахад бэлдэнэ. Хандгай бол ой тайгын их хүчтэнээс гадна гоц соргог адгуусны нэг мөн. Хүйтний улиралд амьтны сонсгол маш сайн байна. Хүйтэнд доргисон цойлсон анир чимээнд зохицон явж чаддагт тэр амьтны амьдрах нэгэн онцлог оршиж байна. Чоно сүрэг рүү нь ойртох хооронд манж хандгай чонотой тулалдаж чадах хүчин чадалтай хэсгээ эзэмшил нутаг дотроо хуваарилан гаргана. Тэгээд нутаг, сүрэг рүү нь зориглон орж ирсэн чоныг нэхэн хөөнө. Тийнхүү зориуд өнөө хуваарьтай газруудад нууцлан гаргасан хандгайнуудруугаа хавчин шахаж өртөөлөн хөөсөөр заавал ална. Хандгай, чоныг хажуу хавирганыхаа ижил сүргийн хуваарьтай нутаг руу хулжаан одуулж байсан удаа ер үгүй. Хандгай чоныг үзсэн л байвал алахаас нааш салдаггүй гэдэг ийм учиртай.

Намар орой болов. Энэ намар дэлт саарлыг энд тэнд үзэв гэж ярилцаад байх болов. Ер нь дэлт саарал энэ жил яаж ийгээд малд халдах гээд байх болов. Энэ ч нэг л учиртай гэж ярилцах нь ч сонсдоно. Дэлд саарал мал эрсэн огтын өөр ажил төрөлтэй яваа хүмүүстэй хаа л бол тааралдаад байх боллоо. Дэлт саарал өөрийн нь алах арга чадалтай хүн, алж үл чадах арга мэхгүй хүн хоёрыг ялгадаг гэдэг үнэн юм гэж түүнийг харсан, буу зэвсэггүй явсан хүмүүсийн өгүүлэх нь бас ч оргүй үг биш бололтой.

Дэлд саарал ер нь яах л гээд байгаа бол доо!

## Хоёр. Хул азарга

*...Өмнөөс нь харахаар*

*Мянган агтын өлзийтэй*

*Түмэн агтын хишигтэй*

*Араас нь харахаар*

*Агт бүрийн байдалтай*

*Аранзулын шинжтэй*

*Хүлэг биш*

*Хүрэл эрдэнээр бүтсэн*

*Наян найман шанхаг нь*

*Наашаа цаашаа цацарч явдаг*

*Нарийн сайхан*

*Хул азаргатай билээ л ...*

***(Ардын туулаас)***

Бор, бага үдийн үед Дулмаагийн д хүрч ирэв. Гэмт хүн гэлбэлзэнэ гэгчээр Борын царай жигтэй уруу дорой байгааг харсан Дулмаагийн зүрх пал хийв. Дулмаа хуучин муу савхин гутал өмсчихөөд гэрээ тойруулан цасны ус гүйлгэхэд шуудуу татаж байсан хүрзээ ч хэдийн газар алджээ.

- Яав юу болов? Адуу чинь алга болж уу? Гэж Дулмаа асуув. Ингэж асуухдаа түүний хоолой сөөнгөтөн нүд нь нэг л хачин харагдав.

- Адуу ч байнаа. Харин...

- Юу харин гэж?!

- Азарга байдаггүй ээ!

- Азарга ий?

- Тийм!

- Одоо хул азарга уу?

- Тийм!

- Яасан хачин юм бэ?

- Харин тийм!

Тэр хоёр морьтой явган нэг нэгийгээ харан түр чимээгүй болов. Хоёулангийн нь нүүр айсан гэмшсэн шинжтэй. Дулмаа Борын морины хөлөрсөн, ядарсныг хараад,

- Чи тэгээд хул азаргаа эрж, муу морио бүр сарьсалж гүйцээ шив дээ?

- Харин тэглээ.

- Наадахыг чинь одоо сайн уяргүй бол сүйд болно доо.

- Ёстой ёстой!

Тэр хоёр, түр дуугүй болов.

- Би чамд ёр шиг хэлсэн шүү! Энэ тэнгэр нэг л ёозгүй байна. Цас орно. Цааш нь юу ч болж мэднэ. Адуугаа манаж хоносон нь өлзийтэй болох дог шүү гээд байхад хул азарга байхад энэ харанхуйд миний адууны дэргэд сөөсийж явах нь илүү зан гээд чи тун явж өгөөгүй билүү! Чи бид хоёр ч нэг ийм юм сонсох гээд байсан юм даа. Хавийн амьтан одоо намайг л муу хэлнэ дээ. Адуу манаж явсан хүнийг хүртэл нааш нь нааш нь гэж татаж чангаагаад байж энэ дээ гэхээс аваад ер юу юу гэж шуугих бол доо! Гээд Дулмаа нүдний нулимс цайруулав.

- Наад ус чинь дахиад хаяан доогуур ороод ирлээ. Чи яагаад таг чиг болчихов оо... гэсээр гэрээс гарч ирсэн эх нь Бор Дулмаа хоёрын урвайсан уйлагнасан царайг хараад,

- Мөн дөө, өнөө хэдэн унаганаас нь уулын нохой...

- Үгүй ээ ээжээ, хул азарга алга болж гэнэ.

- Еэ хайрхаан!... Бүүр байчихаад уу?

- Үгүй чи, наад мориныхоо нурууг түр ч болов амрааж үзээч гэж Дулмаа нүдээ арчин өгүүлэв.

Бор мориноос буув.

- Унага даага тоо бүрэн байтал азаргы нь аваад явчихдаг эрлэг гэж ямар эрлэг байдаг билээ энэ чинь? гэж Дулмаа асуув.

- Ээжээ, хул азарга яасан байж таарах вэ? гэж Бор асуув.

- Яасан ч байж болно хүүхэд минь. Одоо энэ чинь тун хавгүй юм боллоо доо. Яаж байгаад азаргаа алдлаа гэх болж байна. Тэнгэрийн муухайд малчин хүн малаа харж ханддаг байхад, чи даанч гэрлүү шигдээд байл уу! Дулмаа бид хоёр чамайг хөөж тууж ч болтугай үзсэн шүү. Суурийн ахлагч амнаас ч салахгүй юм боллоо доо. Ингэж байтал өнөө гахайнд явсан өвгөн ч ирнэ...

- Ээжээ, хул азарга тэгээд яасан байж таарах вэ?

- Яасан ч байж болно. Дэлт саарал энэ зун намрын турш нэг л догшиндуу байна гэлцээд байсан билүү! Тэр чинь хөөгөөд зайлсан ч байж мэднэ шүү.

- Тэгсэн бол одоо яана аа.. гээд Дулмаа нүүрээ даран гэрлүүгээ оров.

- Чи одоо ингэж модон өмдтэй юм шиг зогсоод яах нь вэ. Би ямар хул азаргыг чинь хөөгөөд явчихсан биш, Гэрт ор! Зуухан дээр халуун цай байна. Ууж аваад явж үз... гээд Дулмаагийн эжий хүрз барин шуудуу татаж эхлэв.

- Тэгээд одоо яавал дээр вэ? гэж асуугаад Бор ханцуйгаа сэгсрээд дээлээ гүвэв.

- Би чамд юу гэх юм бэ! Ердөө л суурийн ахлагч дээр оч. Үнэн учраа хэл. Яавал дээр вэ? гэдгийг ёстой л тэнднээсээ асуу! гэв. Бор, морио хөтлөн уяан дээр очив.

- Хажууд нь энэ тэнгэрийн байж байгааг. Морь халитарч унчих гээд ер урагш гишгэдэггүй шүү.

- Тэнгэр чамд буруутай биш ээ. Чи тэнгэрт буруутай. За за бушуухан орж аяга халуухан юм уугаад хөдөлж үз...

Бор гэрлүү оров.

- Муу эрд давхар давхар дараатай юм болсон бий. Сургуулийнхаа ахлагчаас чи, шан хүртэх цаг чинь болсон бий. Охин бид хоёрыг элэг бариад даан ч явж өгөөгүй юм. Ядахдаа өвгөн маань байсан бол ч чи үг хэлэх байтугай ганцхан эвгүйхэн харахад нь лүг сүггүй гарч адуугаа манаж хоносон байгаа шүү дээ. Тэгсэн бол яалаа гэж ийм хэрэг мандах билээ үглэсээр Дулмаагийн эжий шуудуу татаж байхад гэрт Дулмаа бас л,

- Хул азаргын толгой залгисан байвал чи дахиад наашаа харсны хэрэггүй шүү. Мал маллаж байж амьжиргаа залгана уу гэхээс биш, намайг манаад чи юу олох юм бэ? Чи ер нь намайг л манаж байж малчин болно гэж боддог бололтой байдаг шүү. Чиний манасан манаагүй, би энэ гэрээс гарч хаана очих билээ. Миний ажил, миний амьдрал энэ гэрт л байх шүү дээ гэх мэтээр ярьж байх нь сонсдов.

Хангайн нутагт түрүүчийн цас унаад хэд хоног сүрхий хүйтрэн аядсанаа эргэн дулаарч, цас хайлан уулын энгэрт байсан айлууд цасны усанд авгжээ. Гэтэл өнгөрсөн шөнө бас цас нэмж оров. Цасны ус гэрийн хойт хаяагаар орж гал голомтны хоёр талаар нилдээ урсаж, үмх үүс эд хогшилоо орон дээр хураах нь хурааж, авдар сав, араг шуудайтай үзйлдээ ивээс шургуулан



хөндийр ч өөрсдөө дүрвэсэн амьтад шиг гал цогтой зуух тойрон эндэж гэндсэнээ ярилцан инээд хөөр болох нь болж байна аа. Гадаа гарвал хааяагүй ус мэлийнэ. Тугалын зэл, малын хот, морины уяа цөм ус. Аргал түлээн доогуур ч ус оржээ. Багачууд хүүхдийн хөлдөө өлгөсөн гутал гүзээ шиг шалчийжээ. Саальчид үнээгээ сандал, тайрдас тавьж эвсэл хувин нөмрөн сууж саана.

- Дулмаа! Гэж ээж нь дуудахад,

- Өөв гэж Дулмаа хариу дуугарав.

- Зүүн хөтөл дээгүүр аавын чинь морины зүстэй морьтой хүн даван ирэв. Ардаа юм чирсэн ч юм шиг, үгүй ч юм шиг. Миний хүү гарч хараа гэв.

Дулмаа гэрээс гаран харснаа,

- Аав мөн л байна. Урт чиргүүл дээр бараан юм чирсэн байна. Гахай унагаж дээ... гэтэл Бор гэрээс гарч ирээд малгайгаа өмсөв.

- Чи аав ирэхийг хүлээхгүй юу? Гэж Дулмаа өгүүлэхд,

- Яршиг яршиг, бушуухан далд орёе чи минь гээд Бор мордоод давхин одов.

- Өнгөрсөн шөнийн цас дэлт саарал хоёр ч хул азаргын амыг аван одоо ч болов уу даа. Бор айж сандрахдаа дан морио гундтал даавуу дээлээ гандтал азаргаа эрж явсан шиг байна. Унасан морь нь сүрхий цуцсан байна гэж Дулмаагийн ээж өгүүлэв.

- Энэ ер нь дэндүү дураараа загних гээд байх болсон нөхөр байгаа юм. Хүний үг сонсоно гэж ер үгүй шүү. Суурийн ахлагчтай яриад цааш нь бригадын зөвлөл эвлэлийн үүрийн нарийн бичгийн дарга цөмд нь хэлж байгаад одоо л нэг сайн чих нь мушгиулж авахгүй бол горьгүй шүү гэж Дулмаа өгүүлэхэд

- Хул азарга үрэгдсэн бол ч Бор адуунаас салах өнгөрсөн л дөө. Адуугаа ёстой л сүүдэр шиг дагана гэсэн үг. Чоно гэдэг чинь чоно шүү дээ та минь. Юуны тулд азаргыг нь аваад одсон гэж санаж байна...

- Ээжээ та тэгээд хул азаргыг чоно муулсан гэж бүр нэг итгээд байна уу?

- Орооноос саяхан гарсан, ядарсан хөгшин азаргыг дэлт саарал одоо л нэг дөнгөвөл дөнгөх цаг болсон гэдгээ мэдэх байлгүй.

- Ээжээ та нэг л эвгүй юм яриад байх чинь!

- Би бүсгүй, зөөлөн сэтгэлтэй эх хүн боловч малчин хүн шүү дээ. Эжий чинь юмны цаадах наадахыг мэдэлгүй яах вэ! Түрүүчийн цасны үед өөр хүний адуу манах ээлж байв. Өнгөрсөн шөнийн цастай цагаар Борын ээлж таарав...

- Ээжээ та ийм юм болно гэж мэдсэн бол Борыг сайн хэлж байгаад адуунд нь хөөгөөд явуулахгүй яв даа.

- Би хэлсээн. Зөндөө хэлсэн шүү дээ. Сөгөөтэйхөн хүн бол сэтгэлд нь юм орвол орохоор хэлсэн. Гэхдээ би муу ёр удсан юм хэлээгүй л дээ. Харанхуй шөнө би юу боллоо гэж тийм муухай амны билэггүй юм хэлж болохсон билээ... Би бас эх хүн. Тэгээд ... аав чинь байхаараа хялалзаад хөөрхийд минь огт нүүр өгдөггүй болохоор нь хэн хэний чинь бодоод ганц шөнө юу л болоо аж даа гэж бодчихсон чинь л буруудаж орхив оо хөөрхий...

Дулмаагийн аав гөрөөч Сандаг хүрч ирэв. Өвгөн хоёр бодон унагаад гөлгөр хусан чиргүүл дээр хайрцаглан боож дараад цасан дээгүүр чирээд иржээ. Өвгөний ирэх бараагаар эмгэд хөгшид, хүүхэд шуухад гээд зөндөө л хүн болчихов.

- Өвлийн үүц бэлтгэх цаг хараахан болоогүй байхад энэ ч харин аятайхан хэрэг байна гэж нэг хүн өгүүлэв.

- Манай энэ хавийнхан ч, Сандаг гуайнхаа ачаар жилийн жилд, хангайн хишиг ангийн шөл амссаар бараг муу зантай болж гүйцсэн улс шүү дээ гэж бас нэг хүн өгүүлэв.

- Хэдэн тайга нохойгоо яагаад авч яваагүй билээ? Гэж бас нэг нь асууна.

- Энэ ч одоо, овоо л том бодонгууд байна. Наад морины чинь нуруу сүйд болоо байгаа даа гэж түрүүн юм ярисан хүн дуугарав.

- За та минь дэмий шуугиад юу хийх вэ! Наадуулыгаа арьс хөрснөөс нь салгаж ам хүрэхийг бодоцгоо. Надад ч наадахтай чинь ноцолдох чадал алга. За тэгээд өнгөрсөн шөнийн цаснаар дажгүй юу! Өнөөдрийн дулаан, энэ цасны хайлж байхыг харав уу! Энэ тийм ч сайн базаалтай сайн юм бишшүү гээд Сандаг гэр лүүгээ явтал Дулмаа,

- Ээжээ би үхэртээ явъя гээд алга болов.

- Охин минь өдийд үхэртээ хэзээ явж байлаа гэж Сандаг үгүүлтэл,

- За за гэртээ орж бай гэж эхнэр нь өгүүлэв.

Охин, эхнэр хоёрынх нь байдал Сандагийн сэтгэлд нэг л сэрхийсэн юмны сэжүүр цухуйлгаад орхилоо.

Борын адуулж байгаа хул азаргатай адуу хэд хэдэн адуучны нүүр үзсэн түүхтэй. Энэ хул азаргатай адуу ямар адуучны гарт байх нь ер ялгаагүй билээ. Учир юу гэвэл хул азаргатай адууг хүн малладаггүй. Хул азарга өөрөө ижлээ малласаар өдий хүрсэн билээ. Хул азарга шиг омголон сүртэй адгуус энэ нутагт урьд ч бараг байгаагүй, одоо ч бараг байхгүй гэж энэ нутгийнхан домоглон өгүүлдэг юм. Хул азаргын сүрэгт нутгийн чоно олонтаа халдаж байсан удаатай. Гэвч хул азарга нэг ч удаа унага дааганд чонын соёо шүд хүргүүлж байгаагүй юм. Хул азаргын цог золбоо, хийморийн тухай нутгийн ардын дунд ч өчнөөн сайхан домог яриа буй болжээ. Хул азарга чоныг яаж цавчиж, яаж самардан, яаж дайрч хазах буюу дээр нь

тоглодог тухай, яаж өшиглөн алдаг тухай нүдээр үзсэн хүний үг шиг олон сонин үлгэр түүх нутгийн олны дунд бий болжээ. Үнэндээ хул азарга энэ завсар адуулсан эзэндээ, өшиглөж алсан, дээр нь тонгочиж хэмхчсэн олон чоно тушааж байжээ.

"Барагтайхан анчинд чоно алах хуваарь өгснөөс баттайхнаар хул азарганд хуваарь өгсөн нь дээр" гэдэг яриа гарсан бас ч учиргүй үг биш бизээ. Нутгын чононууд ганцаараа, хоёр гурваараа, тав арваараа хэдэн жил хул азаргатай үзэлцээд ер өөдөө гарсангүй ажээ. Өвөл, хавар, зун намар хул азаргатай үзээгүй цаг нутгийн чононд ер ховор байна. Чононууд хул азаргыг унагахсан гэж хүсэхэд хул азарга чононуудыг олноороо ирээсэй гэж хүсдэг юм гэж нутгийн олон ярина. Бас зарим нь хул азаргыг хийморьтой сэргэлэн байлгая гэвэл чонотой нутагт л нутаглах хэрэгтэй гэнэ. Тэгэхэд зарим нь сайхан юм үзье л гэвэл хул азаргатай адуу л малла гэдэгүг гарчээ. Ийнхүү нутгийн чононууд хэдээрээ ч нийлээд хул азаргыг дийлэхийн заяагүй болохдоо дэлт сааралтай нийлсэн юм гэдэг яриаг зарим хашир анч гөрөөч нар ярих болжээ. Дэлт саарал хул азарганд сүүлийн хоёр, гурван жилийн дотор хэд хэдэн удаа халдаад үзжээ. Эхний учраануудад хул азарга халдашгүй бэрх адгуус санагдсан бол сүүлийн үед хул азаргыг дөнгөж болмоор санагджээ. Гэвч энд дэлт саарал ганцаараа үзэлцэж байгаа юм биш, түүний хажуугаар нутгийн чонон сүрэг үүрий нь хөндсөн шоргоолж шиг язганан хамжилцаж байгааг дурдалгүй яах вэ. Дэлт саарал гарч ирснээс хойш хул азарга баахан зориг мохоо болжээ. Тэр дундаа, эхэн үед дэлт саарлын цөсийг цалгиаж байсан боловч сүүлийн үед дэлт саарлын сүрэг ч олон болсон, дэлт саарал эзнийхээ "төлөө" тэдний улангасан, уулгалан, нүүр нүдгүй довтлох нь хэтэрхий ширүүн болсонд хул азарга баахан зориг шантрах болжээ. Хул азарга олон жил болж хэдий санаа байвч үнэхээр хүчин чадал барагдаж, нас дарж яс өгөрч эхэлснийг мэджээ. Гэтэл чонын сүрэг улам олширч тэдний арга заль гэж мундахгүй олон зүйл болжээ. Хул азарга үнэхээр хүчин мөхөсдөж чадал барагдан айсуйгаа өнгөрсөн зун мэджээ. Зун нэгэн айхтар аянга цахилгаантай үед борооны үеэр хул азаргын сүрэг рүү дэлт саарал сүргээ дагуулан дайрчээ. Энэ тулалдаанд үнэндээ хул азарга гарцаагүй унахад хүрсэн боловч аз тохиож, мал эрсэн хөндлөнгийн эрэлчин хүн тохиолдож дэлт саарлын шийдсэн сүрэг рүү дайран орж, ганц нэгий нь буудан алж, бусды нь хөөн зайлуулжээ. Гэвч энэ удаа үнэндээ хул азарга ялагджээ. Яагаад вэ? гэвэл урид нь чонын сүргээр тохуу тоглоом хийдэг байсан хул азарга энэ удаад чоны шүдийг өөртөө хүргэж хэдэн газраа чононд хэгз татуулжээ. Малчид, хул азарга ингэж чононд ам хүргүүлсэнд сэтгэл зовж,

- Ямар чоно ингэж чаддаг билээ?

- Хул азарга маань больж доройтож байгаа хэрэг.

- Нутгийн чононууд хул азарганд халдаж чадахгүй болохоор дэлт саарлыг ирүүлэв бололтой...

- Дэлд саарал ер нь догширч эхэлсэн нь нэг л учиртай гэж ярилцав.

Тийм ээ, нутгийн чононууд олон жил хул азарганд сарьсан хамраа тас өшиглүүлж, сарайсан шүдээ үй цохиулжээ. Эцэст тэд дэлт сааралтай "хуйвалджээ". Эхний үед дэлт саарал хул азарганаас чамлалтгүй "шан" хүртсэн авч, хул азаргыг олон дахин эргүүлж тойруулан, элдэвлэн үзсээр байжээ. Дэлт саарал хул азаргатай сүүлийн хоёр гурван жил олонтаа үзэлцэхдээ хул азаргыг асар удахгүй унагаж болно гэдгийг "мэджээ". Хул азарга ч дэлт саарлын мэхэнд ойчно гэдгээ "мэджээ". Тийм дээрээс ч хул азарга манаатай шөнө "сэтгэл

амар" хонодог, манаагүй шөнө сүргээ дагуулж айл малын зах бараадан ойр хонодог болжээ. Борыг манаанд гарсан зарим шөнө хул азарга бие амар байдаг, заримдаа Бор хаяад явчихаар нь яах ч арга олохгүй түгшиж хонодог болжээ. Гэтэл өнгөрсөн шөнө цас орлоо. Бор байдаггүй. Бор хэдийд үзэгдсэн бэ гэвэл наран уулын цаагуур унасан даруйхан адууны дэргэд давхин ирж, бүх адууг эргэн тойрон жаахан давхиж дэмий баахан хашгирч гуугачсанаа адууг айлын зүг ойртуулж хаячихаад давхин очжээ. Борыг давхин одохтой зэрэгцэн цас унаж эхэлжээ. Цастай шөнө яаж тэнгэр нүдтэй байхсан билээ. Хул азарга ижлээ айл малд ойрхон эргүүлсэн байтал үүр цүүрээр дэлт саарал дуулгаварт сүргийн хамт дайран орж иржээ. Хоёр гурван жил хул азаргыг сүүдэр шиг даган, дийлэх нэг өдөр буюу аян шалтаг, аятай мөч ирэхийг хүлээж байсан дэлт саарал ийнхүү орж иржээ. Хул азарга энэхүү үүр цүүрийн тулалдаанд дэлт саарал түүний хамсаатантай урьд өмнө үзэгдээгүй их хүчийг гарган ижил сүрэг нь дуулаагүй сүрт авиа дуу тавин үзэлцсэн боловч түүнд ижил олон сүргээс нь нэг нь ч нэмэр болсонгүй, эзэн хэмээгдсэн Бор нь ч ирдэггүй байна. Намар оройтсон цагийн чоно гэдэг эгзэг нь таарвал юу руу ч довтолж, юу ч хийж чадах ааш араншингаараа хул азаргыг довтолсоор түүнийг ижлээс нь ганцаардуулан тасалж авчээ. Чоно хамгийн шийдсэн мэх гохоо хийдэг цаг намар оройтсон цаг билээ. Намар оройн сэрэглэсэн чоно гэдэг дийлэхийгээ байтугай, аль дийлдэггүй эсэргүүцэгчтэйгээ ч хаа хэдийд ч үзэлцэхэд бэлэн байдаг жамаараа хул азаргатай үзэлцжээ. Хул азарга ижил сүргээсээ ямар ч дэм дэмлэг үзэж чадахгүйгээ мэджээ. Цөөн тарган морьд хул азаргыг өмөөрөн хэд хэдэн удаа сүр бадруулан унагалдаж шуугин орж ирсэн авч олон чоно огт халгаасангүйд арга буюу буцжээ. Тэгээд тэрхүү цөөн тарган морьд бүх ижлээ авч газар донсолгосон их чимээ сүрээр дайрч хул азаргаа аврах гээд үзсэн ба бүтсэнгүй байна.

Тэгэхээр нь унага даагаа дагуулсан гүүнүүд гэр хотын зүг бөөн шуугиан тавин одох гэсэнд санаа муут чонын хэсэг нь бас замы нь боогоод явуулсангүй. Эдгээр чоно энэ шөнө хул азаргыг яавч дийлнэ гэж мэджээ. Хул азарга ч нас явсан, яс үйрснээ мэдээд энэ шөнө яаж ийгээд гэрийн зүг оддог арга юу байна вэ? гэдгийг элдэвлэн "боджээ". Яаж ийгээд гэрийн зүг эс олдвол салгаж болдоггүй аман хүзүү, хатан хүзүү хоёр ч саллаа гэж "мэджээ". Тэгээд хул азарга ч байдаг хүчин чадал, арга мэх бүхнийг гарган дэлт саарал түүний сүргийг дайрах газар дайрч, хийж болох арга мэх бүхнээ хэрэглэн гэрийн зүг тэмүүлсэн боловч гэр мал ч тийм ойрхон байсангүй, хэл мэдээ ч хүрэх амьтан гарсангүй. Тэгээд хорт чонын сүрэгт хүчинд автан туугдсаар оджээ. Ард нь үлдсэн ижил сүрэг нь унгалдаж янзгаан азаргаа баахан дагаж хошууржээ. Адаг сүүлд нь "Аврал эрэн" адуучин эзэн нь амар сайхан дугжирч байгаа, айлынх нь гэр, мал хотыг нь хүй дайрчих шахан пижигнэн шуугин орж үзжээ. Гэвч юу ч болсонгүй байна. Азаргагүй хоцорсон адуун сүрэг, хорт чонын хулжаан одсон хул азаргын араас ч хуйлраад дэмий болж, хонгор хүүхнийхээ хүзүүрүү хошуу шургуулан унтаж байгаа эзнээ ч сэрээж чадахгүй ингээд хоцорчээ. Чоно атаач жөтөөч! Чоно хорлон хорсголонттой гэдэг ийм байдаг ажээ. Чоно дайралдсан малаа барихаасаа өөрт нь дайсагнадаг малыг унагах гэж илүү хичээдэг гэдэг нь энэ буй заа.

## Гурав. Домог

*Аж амьдрах гэдэг тун бэрх ажээ. Түмэн удаа ялж давсан боловч нэгэн удаа осолдохууд хамаг хэрэг явдал буруудах нь тэр.*

**Э. Сетон-Томпсон.**

- Өнгөрсөн шөнө өнөө гайхал Бор... адуу манах... чаан... болох... гүй байсаар... гэж эхнэр нь өгүүлэнгүүт Сандаг.

- Тэгсэн байж таарнаа тэр! ... Түрүүн намайг гэрийн гадаа ирж буухынх та хоёрын царай бүр нэг янзтайх ан харагдаад байсан юм. Энэ муу Бор золиг хүний үг мэддэггүй яасан донгио толгой вэ! Үлий сахисан сар шиг, миний бөгс хаашаа харж харуулдахаас өөр юм ер санаж бодохоо байж шүү... Хайран сайхан мал хөөрхий. Үхэх замаараа үхэхгүй тэгэж дэлт саарлын бах тав болж муугаа үзэж үхэх учиртай байж л дээ... Тэгээд, хаана яаж чонын хоол болоо вэ?

- Хаана юу болж суусан нь мэдэгдэхгүй олоогүй байна... Бор өглөөнөөс хойш эрээд.

- Тэр яалаа гэж олох юм бэ. Түүний хоёр нүдий нь хий айдас бөглөчихөөд улаан зам дээр нь хэвтсэн ч харахгүй. Дэмий л унаа морио махалж байгаа нь тэр. Азарга хичнээн хүчин чадалтай тусмаа төдийчнээ өст дайсантай байдаг юм. Дэлт саарал түүний дагуулсан сүрэг, хул азарганаас өшөөгөө авахдаа тийм амархан авна гэж санана уу! Холоо хэвтэнэ. Ёстой нэг бах таваа хангасан юм шиг болгохоо мэднэ шүү дээ. Хэдэн жил хул азарганд дарлуулж доромжлуулсан чоно гэдэг чинь болж л өгвөл түүнийг хага татахгүй шүү! Хул азаргыг барагтайд тун хага татахгүй. Түүнийг харин уулан дээрээс нисгэнэ үү, ганга эрэг дээрээс ёроолгүй цүнхээлд хийсгэнэ үү тэгэж л мууг нь үзнэ. Чонын санаа хар гэдэг чинь их учиртай үг. Дэлт саарал түүнийг тэгэж ижлээс салган аваачиж уулнаас нисгэх юм уу, усанд живүүлж байгаа юм чинь ухаандаа хул азаргыг өөрөө хийсэн нүгэлдээ хахаж үхэж байгаа нь тэр!

Хул азарга алга болсон мэдээ Сандаг өвгөнийг гал цог дээр суулгачихсан юм шиг болгов. Хүний байтугай төмрийн ч үнэр баймгүй хэдэн хар хавхаа гаргаж тавив.

- Хавхаар битгий оролдоорой! Гэж Сандаг хэлэв. Оройхон гэрт хүмүүс гахайн чанаж хөргөсөн шинэ мах, зэрлэг сонгино тавьж алаглуулан идэж байтал суурийн ахлагч, Борыг дагуулсаар хүрч ирэв.

- Байдаггүй! Байдаггүй! Сөртийн цохион дээр хөөж гаргаад тэндээс доош нь нисгээд хаячихжээ. Гэр дэх хүмүүс:

- Ээ эвий гэж!

- Хайран, хайран!..

- Хайран сайхан мал!

- Сөргийн цохионоос өөр хул азаргын толгой залгих адармаатай газар энэ хавьд байхгүй л дээ!..

- Хөөрхий минь, хөөрхий минь, аврах хамгаалах хүн, газрын хаанаас гараад ирдэг бол гээд яаж ийш тийшээ харан бүлтэлзэж явсан бол доо!..

- Уг нь мал шиг малдаа л тэр хүртэл чононд хөөлгөн давхиж дээ. Түүнээс биш хул азарганаас өөр мал байсан бол замд хийсээд өгөхгүй юу! Сөргийн цохио гэдэг чинь хаа байсан газар вэ!

- Чоно гэдэг ийм л сүнсгүй араатан даа. Чоно өлссөндөө тэнд хүргэж байгаа юм биш, өшсөндөө тэнд хүргээ шүү дээ. Өшөө хорсолоо авах гэж хавийн бүх чоныг цуглуулаа шүү дээ. Тэгээд дийлсний бах болгоод хул азарганд чононууд бараг ам хүрэхгүй зайлсан байгаа биз дээ? Гэж Сандагийг асуухад,

- Тэгсэн байна лээ. Ер нь тэгээд хайр ч хүрэхэд, гол ч харлаад хөөрхийг харж ч болдоггүй шүү гэж суурийн ахлагч өгүүлэв.

- Ганц хамгаалагчийг нь унагаж авсан хойно, одоо энэ адууг ч холих байгаа даа гэж нэг хүнийг дуугартал,

- Энэ нөхрөөр хул азаргыг төлүүлээд хэдэн адуугаа өөр хүнд өгөхгүй бол барна гэж үү гэж суурийн ахлагч өгүүлбэл,

- У –уу –хай! Өнөөдөр энэ нөхрийг адуу маллаж чадахгүй нь гээд тэр адууг өөр хүнд өгдөг байж. Маргааш бас нэгийг нь сааль сүүний ажил хийж барахгүй нь гэж хэдэн үнээг нь салгаж авна. Ингээд л аль өөдгүй, аль унхиагүйх нь толгойг илээд байвал энэ ардын нэгдлийн малыг чинь хэн хариулах болж байна. Хул азаргын хүчинд наадах чинь өнөөдрийг хүртэл үнэндээ адуу манаж байгаагүй юм. Яг үнэнийг нь хэлбэл, бид гуравыг л манах гээд байдаг эр байгаа юм. Одоо нэгдлийн адууг маллахгүй яах юм бэ! Хул азаргын ачаар ихээхэн дураар байсныхаа хэргийг одоо хийлгүй яах вэ? Малыг эзэн хүн шиг, малчин хүн шиг маллаад байсан бол яалаа гэж ийм хэрэг гарах вэ!.. гэж Сандаг өгүүлэв

Дулмаа гэртээ болж байгаа ийм гурвалжин дөрвөлжин яриаг гаднаас чагнаж байснаа сүүлдээ үнээгээ сааж эхлэв.

- Одоо нээрээ яах вэ? гэж суурийн ахлагч асуутал,

- Яах ч арга байхгүй ээ. Ганц олигтой малладаг азаргыг нь чононд өгчихсөнөөс хойш одоо малаа малчин хүн шиг малладаг хэрэг. Чонотой ч анчин шиг тэмцдэг хэрэг гэж Самдаг өгүүлснээ,

- Гадаа хэдэн хар хавх гаргаад тавьчихлаа. Бор чи одоо ганзаглаад яв! Хул азаргын унасан газар аваачиж зүүгээрэй гэхэд Бор дуугарсангүй.

- Чи яагаад дуугарахгүй байгаа юм бэ? Чоно алчихвал тэр чонын өшөөнд бусад чонынх нь хоол болчихвий гэж айж байна уу чи? Чоно адгууснаас өшөөгөө авч байхад хүн, араатнаас

өшөөгөө авах ёстой. Өнөө шөнө дундаас хойш цас орно. Маргаашжин орчиж мэднэ. Миний хэдэн хавх дэлт саарлын нэг л мөчнөөс хэмхсэн байвал тавина гэж ярихгүй дээ. Дэлт саарал энэ жил бүр нэг шил заах болоод байгаа юм. Үхэх оготно муурын сүүлээр оролдоно гэгч болж байгаа вий. За залуу минь наад махнаасаа ид! Мордож үзье! Гэж Сандаг өгүүлсэнд,

- Мордож үзье гэдэг үгийг дуулангуутаа зориг орсон Бор доош харан гахайн махнаас огтлон зажилж эхлэв. Өлссөнөө бодвол том түмпэнтэй гахайн их махыг цөмийг идчихмээр байвч, гэмт хэрэг хийсэнд бантаад Бор дэвтэй ч юм хоолойгоо давуулж тэгсээр болив.

Хүмүүс хул азаргын явдлаас болж олон сайн азаргын тухай ярьсаар нэгэн халиун азаргын тухай домогт шилжлээ.

Урьд энэ нутагт Хонгор гэж нэгэн баян хүн байж гэнэ. Хонгор баян хичнээн мянган толгой малтай, түүний хичнээн нь адуу байсныг одоо хэлэхэд бэрхтэй гэнэ. Хонгор баяны олон азарган дотор нэгэн сайхан халиун азарга байж гэнэ. Халиун азарга залуу зандантай байтугай нилээд хөгширөөд байхдаа ч гэсэн ижил сүргээсээ ганц унаганд ч чонын шүд хүргэж үзээгүй юмсанжээ. Халиун азаргын хөшиглөж, хэмхэлж алсан, ууц нурууг нь хугалж, үе мөчий нь хуга нуга гишгэлж дэвсэлсэн чоно хэд хүрсэнийг хэн мэдэж дээ. Халиун азарга он жил өнгөрөхгүй тутам өтөлж хөгширч, өнөө гайхамшигт хүчин чадал нь буурч доройтож эхэлдэг байна. Халиун азаргын ингэж сульдаж доройтож байгааг хангайн хар амт чоно ч ажин харсаар байж гэнэ. Тэгэхдээ чоно халиун азаргын эр чадлын харьж байгааг ердөө л хараад байсангүй, түүний ижил сүрэгт өөрт нь ч халдаж "сорьж шалган" үзсээр байжээ. "Нохой эзэнтэй байхад чоно сахиустай байдаг" гэдэг урьдын үг. Тэгээд нэгэн намар өдийн үед хангайн сүрэг чоно халиун азарганд халджээ. Чоно олуулан юм байжээ. Халиун азарга ч сайн үзэлцжээ. Гэвч халиун азарга хангайн сүрэг чоно хоёрын энэ удаагийн тулалдаан хичнээн цаг үргэлжилж яаж төгсөх байсныг хэн ч мэдсэнгүй. Яагаад гэвэл халиун азаргын сүргээс баахан унагатай гүү тасран гарч эзэндээ давхин иржээ. Унагатай гүүнүүдийн усан хулгана болтол хөлөрсөн, унагалдан шуугих байдлаар адуунд аюул болсныг эзэн нь мэджээ. Хүмүүс тэр дор нь морджээ. Адууныхаа бэлчээр дээр хүмүүс давхилдан хүрвэл өнөө халиун азарга чинь бөөн чонын дунд хүч үзэлцэж байж гэнэ. Хурдан морьтой буутай хүмүүс дайран орж хангайн хар амт чонууд зугтах нь зугтаж, алагдах нь алагджээ. Хөөрхий халиун азаргыг харсан чинь түүний ядарсан цуцсан гэдэг нь харахын эрх алга гэнэ. Олон чонын аюулаас салгасанд эзнээ хараад үүрсэж байх нь эрх танхи амьтан баярлан баясаж буй мэт харагдсанд Хонгор баян,

- Хангайн хайрханыг минь цас дарж

Халиун азаргыг минь нас дарж дээ гээд уйлсан гэдэг юм. Тэгээд үзсэн чинь халиун азаргын биед чонын шүд зөндөө хүрсэн байжээ. Тэр хэсэг унагатай гүү яаж тэгж тасран гарч эзэндээ "хэл мэдээ" хүргээ юм бэ зайлуул! Мал их хачин шүү. Агт морьд нь бөөн бөөнөөр халиун азаргаа хамгаалж түүндээ "туслах" гэж байдаг чадлаараа чоноруу үе үе дайрч байхад, гүүнүүд нь яаж ийгээд эзэндээ давхиж хүрээд "хэл ул" болчихдог байна шүү! Ингэж эзэн мал хоёрын заяа түшээгүй бол халиун азарга хөөрхий болох байжээ. Хонгор баян түүнээс хойш халиун азаргын сүргээ хол ч бэлчээдэггүй, шөнө манаагүй ч хонуулахаа байж гэнэ. За тэр намар яах вэ тэгээд өнгөрөө л биз. Дахиад л өвөл болж, халиун азаргатай адуу "Гургалдайн тохойд" байжээ. Одоогийн манайхны "Азаргын тохой" гэж нэрлээд байдаг энэ тохойн маань жинхэнэ нэр нь "Гургалдайн тохой" гэдэг юм гэнэ лээ. Урьд үнэндээ гургалдайтай ч байсан сүүлд

азаргын тохой нэртэй болохоос өөр аргагүй ч болсон юм байж ээ.

Мөс хадаалжээ. "Гургалдайн тохойд" жилд мөс нь аниж битүүрдэггүй үлддэг мөнх хар ус нэртэй хар өрх мөн тэр өвөл харласаар л байж. Хонгор баяны халиун азаргатай адуу тэр тохойд өвөлждөгөөрөө өвөлжиж л байж.

Цас оржээ. Хүйтний эрч өдөр хоног өнгөрөх бүр чангарсаар байжээ. Дахиад цас... Сүүлдээ ойрын хичнээн ч жил юм бэ бүү мэд, өвгөд хөгшдийн үзээгүй их цас унаж гэнэ. Хамгийн сүүлчийн их цас унах үеийн тэнгэрийн муухайрсаныг өгүүлэвч баршгүй болж. Тэр үед мал хотноосоо, хүн гэрээсээ толгой цухуйлгах байтугай чоно ч орогносон нүх хонгилоосоо хар хошуугаа гаргах аргагүй байж. Салхи, чононд их өлзий болдог. Хүн, төмөр, хоол хүнс, өөр бус аюултай аюулгүй юу хаана байгааг салхины хүчээр чонын хамар цөмий нь мэднэ. Чонын хамгийн итгэлт туслагч бол түүний сарьсан хамар билээ. Харин ийнхүү сүүлчийн их цасны үед мал сүрэгт ямар нэгэн гай зовлон тохиох бий гэж хэн ч хэрсүүрхсэнгүй байна. Тэнгэр газар нийлчихээд хүн шөнө бүү хэл өдөр, хэдэн алхамын цаана юу байгааг харахын эрхгүй байхад үнэндээ яах ч юм билээ. Юу гээчийн юм болох юм бол доо гэж хүмүүсийн сэтгэл түгшжээ. Тэгсэн чинь "тэнгэрийн муухай арилдаг" гэдэг үнэн юм чинь. Их цас ч унаж гүйцжээ. Тэнгэр ч онгойжээ.

Тэнгэр цэлмэж цийлгэнэсэн хүйтэн өглөө болж хүмүүс босчээ. Хонгор баяны халиун азаргын сүрэг гэрийнхээ гадаа шавчихсан зогсож байдаг байна. Хүмүүс анхандаа тэнгэр эвгүйрхээд адуу гэр хотоо бараадаж дээ гэж бодлоо. Бөөр бөөрөөрөө нийлчихээд бөнжгөнтөл чичрэлдэн зогсож буй их адууг хүмүүс харахдаа цасанд даруулж даарах бээрхдээ л ингэж байна гэж бодсоноос биш, учирсан гай зовлондоо дарагдан гуниж гутран "уйлалдаж" байна гэж огт мэдсэнгүй. Гэтэл тэнгэр эвгүйрхэд адуу гэр хотны нөмөр бараадах гэж баймгүй юм. Адуунд гэр хотны нөмөрөөс "Гургалдайн тохойн" нөмөр илүү биш билүү гэдэг үг яриа үүсэв. Адуу гэр хотоо бараадсан нь нэг л учиртай гээд л шивэр авир ярилцах нь тэр! Хүмүүс, адууруу явлаа. Халиун азаргын сүрэг нь үнэндээ ч хоёр гурван азаргын сүрэг шиг их адуу байж. Ер нь зуны цагт агт морьдыг ижилдээ нийлүүлдэггүй азаргууд намар өвөл болохоор өнөр өтгөн ижилтэй болдог л доо. Халиун азаргын ижилд Хонгор баяны гол хурдан жороо морьд нь байдаг. Энэ нь баян, өөрийн удам судартай сайн малыг хашир манаач, халиун азарга гэдэг хоёр давхар "авдранд" хадгалуулсан хэрэг билээ. Хонгор баян хамгийн түрүүнд хурдан жороогоо "бүртгэв". Тоо бүрэн, толгой мэнд байсанд түүний сэтгэл амарчээ. Дараа нь хүмүүс унага даагаа үгүйлэв. Бас л бүрэн бүтэн аж. Хамгийн сүүлд морь гүүгээ үзэв. Мөн л бүгд байна. Адуу, гэр хотоо зүв зүгээр бараадаж дээ гэж хүмүүс бодов. Тарган цаггалан адуу их цасан шуургаар голоос гарч ингэж "сэрүүцэх" явдал байдаг байх нь гэж бодов. ҮХмүүс гэр лүүгээ явтал нэг нусгай жаал,

- Халиун азарга алга байна шүү дээ! Гэх нь тэр.

"Халиун азарга алга байна шүү дээ!" гэдэг үг Хонгор баяны толгой дээр аянга буух шиг сонсдоход баян, хүүхдийн тэр царгиа дуунд нам цохиулах мэт,

- Юу- у у! гэснээ л доошоогоо толгойгоо тэврэн нам суужээ.

- Үгүй нээрээ, юу вэ энэ чинь гээд л буцаад адуу руу явав.



Адууны дөрвөн талд гарч дотор нь орж шүүж явсан хүмүүст халиун азарга алга болсон нь арга буюу үнэн болов . Хүмүүс морьдоо эмээллэн Хонгор баянтай цуг мордлоо... "Гургалдайн тохой" руу л явж дээ. Адуу байсан газар хүрчээ. Тохойд дулаа оргиод нэг л эвгүй. Тэгсэн чинь юу байх вэ. Сүрэг чонын мөр цасан дээр цоохортоод л явчих нь тэр! Олон чоно иржээ. Тэгээд л адууг голын тохойн хар өрх рүү ээрүүл болтол нь хумьж хураан шахаж гарчээ. Халиун азарга ч чонуудтой хамаг чадлаараа үзэлцээд байжээ. Цусаа цувуулаад одсон ч чоно байна. Дутуу үхэж хэвтэж байгаа ч чоно байна гэнэ. Энд тэнд чонын үс цус ч харагджээ. Халиун азаргын чонуудтай үзэлцсэн мөрийг харахад зүрх өвдөж нүд халтирам байжээ. Халиун азаргын биед чоно лав шүд хүрсэн шинж тэмдэг ч мэдэгджээ. Адуу олон чононд ээрэгдэн шахагдсаар голд тулж иржээ. Ороолж цойлон гарсан ганц нэг морьдыг эхэн үед чонууд буцаан хөөж ирсэн мөр ч байна гэнэ. Адуу сүүлдээ голын хар өрхөд ойртож цөмөрч үхэхийн аюул тулаад ирэхээр арга буюу чонууд руу улайн цайн дайран гарах ганц зам үлдсэн болохоор арга буюу шинэ цастай мөсөн дээр халтирч унаж тусан гарч эхэлжээ. Ижлий нь ингэж цувуулан гаргасаар халиун азаргыг сүргээс нь тасалж үлджээ. Чонууд хаашаа ч гарах аргагүй болсон ганц азарга хуу хамаг хүчээ хөвчлөн улангасаж ноцсоор эцэст хөөрхий халиун азаргыг аймшигт хар өрх рүү халтирган түлхэж оруулжээ.

Хар цооногийн амны мөс хагарч хэмхэрсэн нь халиун азаргыг залгиснаа үзүүлэх мэт харлан байжээ. Тэр цагаас хойш "Гургалдайн тохой"- г "Азаргын тохой" гэж нэрлэх болжээ. Хожим дуулбаас "Азаргын тохойн" тэр хар өрх халиун азарга унасны дараа өвлөөс эхлээд жилийн жилд аньж битүүрэн хөлддөг болсон гэнэ лээ гэлцэнэ.

Чоно гэдэг юутай аюултай, юутай заналтай дайсан болохыгөгүүлэвч баршгүй билээ.

Халиун азаргын гунигт төгсгөл домог уу? Үгүй! Яг үнэн болсон явдал. Ер нь домог бол домог юм. Гэхдээ домог хэзээ ч ор үндэсгүй байдаггүй. Домогт түүнийг төрүүлсэн үр үндэс заавал байдаг билээ!

*Яах ч аргагүй байхгүй ээ!*

*Ганц олигтой малладаг азаргы нь чононд өгчихсөнөөс хойш*

*одоо малаа ч малчин хүн шиг малладаг хэрэг.*

*Чонотой ч анчин хүн шиг тэмцдэг хэрэг.*

**(Сандагийн өөрийн нь үгнээс)**

Сандаг өвгөн үнэн хэлсэн байна. Шөнө дундаас хойш цас орж эхэлжээ. Сандаг уг нь Борыг өчигдөр оройхон дагуулаад гарах гэсэн авч тэнгэрийн байдлыг харсхийж байж мордохоор шийдээд Борыг гэрлүү нь буцаажээ. Тэгээд шөнө дундаас хойш цас орж эхлэхээр мордоод Борын гэрээр дайран одсонд Бор, хул азарга чононд унагаалгасандаа ч ажирсан шинжгүй, худ болох гэж байгаа нэрт анчин өвгөнтэй авд гарах гэж тогтсондоо ч сэтгэл санаа сэрхийх янзгүй унтаж байхад нь аазгай хөдлөөд "ийм үхлэн золиг гэж бас байдгаа..." гэж цухалдахдаа "хүн өөрөө хүн больё гэж бодохгүй байгаа бол би заавал түүний чихнээс чангааж л явах нь юу вэ!" гээд мордоод явтал сэлүүн агаарт гарахаар сэтгэл санаа нь уужрах шиг болжээ. "Насны багад унтах нойрноос болж яваагүй хэн байлаа. Залуу хүнийг ийм цагт чихдэж чирч явж бид л өөрсдөө хүн болгохгүй бол яаж эд чинь хүн болох юм бэ... Муу Бор сүүлд надад ч гомдох байхаа даа. Цагаан цайлган хүү юм шүү... Аав Борыг дагуулаад явахгүй яасан ч муу санаатай юм бэ гэж охин минь ч юм санах байгаа" гэх бодол төрөөд Сандаг өвгөн буцаж Борынх руу ирэхдээ замдаа чөдөртэй морий нь аваад иржээ. Сандаг Борыг дуудан босгов. Хадам эцэг нь болох гэж байгаа хүнтэйгээ ан авд явна гэснийгээ ийнхүү "нойронд худалдчихсандаа" түүний ичиж зовсон нь ч тойм алга. Хам хум хувцаслан,

- Би морио аваад ирье... гэтэл,

- Морий чинь гадаа аваад ирсэн. Харин эмээл чинь хаа байна? гэсэнд Бор бүр ч ичих цочих хосолчихоод,

- Эмээл пинд бий. Би замдаа... гээд Бор түрүүлэн гарахад,

- Миний хүү хүргэн чинь болох гэж гүйгээд байгаа биш. Чи л хүүгээр минь хүргэнээ хийх гээд царай алдаад явна уу даа... гэж Борын аав ээж хоёр үе тэнгийн бөгөөд нутаг нугын хүний хувьд Сандагийг ийнхүү тохуурхахад Сандаг ч мөчөөгөө өгсөнгүй,

- Та хоёр хөгшин толгой ингэж нялцганаад байна хойно, энэ хүүхэд цэлцгэнүүр байх нь долоон зөв... гээд гарч оджээ.

Үүрийн гэгээнээр Сандаг Бор хоёр хул азарга унасан газар хүрчээ. Цасанд дарагдан хэвтээ хул азаргыг хараад Сандагийн царай барайж, байдал нь гунигтай болохыг Бор ажиг байв.

- Малчин хүнд ямар ч алт мөнгөөр сольшгүй хайран хайран гэдэг мал нь байдаг. Тэр минь л

байсан юмсан гээд өвгөн Сандаг нулимсаа арчихад Борын байдал хачин болжээ.

Сүүлд нь Сандаг дахин чамаас өөр хүн адуулсан бол ингэж ч хэвтэх мал биш л байсан юм даа. Ай даа юу ч гэх вэ... гээд Сандаг хул азарга руу алхан одож баруун чихрүү нь юм хийх шиг болов. Онгон дэл, сүүл хоёроос нь хишигний хэдэн хялгас авав. Өвгөн нүднийхээ нулимсыг дахин арчив. Энэ бүхнийг хараад Бор хамаг бие бүр царцах шиг болов. Сандаг газрын байдлыг эргэн тойрон шинжиж баахан явав. Хүн гэдэг чинь хар бага наснаасаа байгаль дэлхийтэйгээ харилцаж түүнд амьдралынхаа турш шалгалт өгч явдаг юм шүү дээ.

- Балайраад зогсоод байвал мөдхөн үхрийн сүүл шиг хуга хөлдөнө шүү чи! Газар орны байдлыг сайн харж ав. Ийм газар хавх зүүж дэлт саарлыг барина гэдэг зангууны үлгэр шиг юм. Гэвч өшөө хорсгол гэдэг зангирч, цус судсандаа багтаж яван булгилж байгаа цагт дэлт саарлыг барих л болно доо. Чи энэ газрыг тун сайн ажаарай. Дэлт саарал хаагуур ирэх вэ! Бусад сүрэг нь хаагуур ирэх вэ! гэдгийг сайн бод! Энд зам хаах газар байна. Чулуугий нь хөндөж болохгүй. Холхноос мөчир гишүү сайтай мод авч ир! Аар саархан биш, даах л модоо авч ирнэ шүү. Энд авчраад мөчир гишүүгээр нь энэ сэтэрхийг хаана шүү. Бор модонд явав. Удаж удаж тэр нэгэн саглагар мод мөрлөн ирсэнд Сандаг харж харж,

- Хангайн модноос олж ирж байгаа чинь энэн үү! Наадах дээгүүр чинь ямаа ч харайгаад гарна. Тэр нэг сэтэрхийд босоодуу тавьж зам хаа даа... Сандаг өөрөө яваад Бор шиг гурван эр даамгүй тийм лужир саглагар мод авч ирсэнд Борын зүрх дахин царцах шиг болов. Сандаг дахиад явав. Түрүүчийнхээсээ том мод олж нөгөө сэтэрхийг бөглөв.

- За, чиний бодоход дэлт саарал одоо хаагуур ирэх вэ?

- Надад ер мэдэх юм алга...

- Зөв! Ийм газар чоно чухам тэрүүгээр ирнэ гэхэд хэцүү шүү. Бага чонууд ирэх газар хоёр байна. Сандаг хэд хэдэн хадны сэтэрхийг зааж энэ үүгээр л могой шиг мурилзаад дамжаад ороод ирнэ. Дэлт саарал үүгээр ирэхгүй. Багуудынхаа мөрөөр дэлт саарал явахгүй. Тэр чинь их дээгүүр жаална. Энэ хадуудыг чинь янгир шиг дамжиж ирнэ. Хамгийн сүүлд цаад ширээ хадан дээр чинь гарна. Тэгээд дөрвөн зүг найман зовхист харж баахан сууна. Санаа гэдгий нь чи чухам юу гэж санана. Хул азаргыг унагаснаас хойш миний араас буутай морьтой, хортой, хавхтай өчнөөн хүн сүүдэр шиг дагаж яваа гэдгийг дэлт саарал сайн мэдэж байгаа... Чухам санааныхаа мууд л цаадах чинь манай энэ нутагт ганцаараа үлдээ шүү дээ. Болж л өгвөл хүний гарт үхэхгүй гэдгийг ёстой нэг хичээнэ дээ. Гэвч тэр чинь дэлт саарал болохоос биш хүн биш шүү дээ. За тэгээд хүн амьтан алга. Зоволтгүйхэн шиг зоогоо зооглоно доо гэхээрээ буцаад ширээ хадныхаа ар луу буугаад дахин буцаад ширээ хадныхаа зүүн мөрөн дээгүүрх намхнаар дамжин ирээд энэ рүү жаахан бууж ирж байгаад тэгээд үсэрнэ... Үсрээд хаа буух вэ гэхээр дээхнээсүсэрч байгаа юм чинь лав гурав дөрвөн метр үсэрнэ шүү дээ. Тэгэхээр энд бууна. Цаадах чинь даанч хөгширч ёстой л од нь унаж яваа золиг л доо. Түүнээс биш есөн шид нь дөнгөж бүрдэж явсан шүдэрхэг, идэрхэн цагтаа сан бол ч ширээ хадныхаа оройгоос үсрэхэд энэ тулга хаданд буугаад энэ тулга хаднаас тэр дөрвөлжин хадан дээр бууна. Тэгээд азарганд хүрэх юм. Тийм газар хавх тавихад хэцүү... Тэгэхээр бидэнд дэлт саарлын хөгширсөн нь ашиг болж байгаа юм. Түрүүчийн миний хэлдэгт хавхаа зүүнэ. Дунд нь том харыгаа зүүнэ. Миний том хар хавх баавгай ч гишгэсэн тавихгүй шүү. Цаад талд нь хоёр хавх

зүүнэ. Яг энд... өмнө хөл нь орж гэхэд буцаад явах гэхдээ суухаар бодож... хоёр хажууд нь нэг нэгийг зүүнэ. Урагшаа юм уу хойшоо явахгүй хар авч хажуу тийшээ явах гэхдээ суухы нь бодож... энд нэгий нь, энд нөгөөгий нь... за газартайгаа ноцолдоно доо. Чулуу шороогий нь яг тааруулж малтана шүү. Ганц биш олон хавх... Дулаанд биш хүйтэнд, өдөр биш өглөө эртийн бүдэг бадагт тун яршигтай санж.

- Ажил өлзийтэй болж мэднэ. Тэнгэр их нааштай байна. цас өнөөдөржин орно. Шөнө дунд хавьд хүрч зогсоно биз. Ийм цагт чоно хүний муу талыг тааруулсан гэхэд бид чонын гэнэдэх үеий нь тааруулахад аятай байгаа юм...

Энэ хавхы чинь дэлт саарал аваад явчихгүй юу?

- Чиргүүл мэргүүл бол чоно шиг хар санаатад хар авахуулахаас өөр нэмэр өгдөггүй юм. Дэлт саарал энэнийг аваад явлаа гэхэд хаа хүрэх юм бэ! Чонын толь бичиг гэгч нь түүний арваад янзын улилга байдаг гэж би дуулсан юм. Тэгвэл хавханд орсон чоно хаа очсоныг бидэнд хэлээд өгөх толь чинь энэ цас шүү дээ. Ийм газар хавхтай чоно хаа хүрэх вэ!

- Дэлт саарал гай таараад хавханд суувал хаашаа явах вэ?

- Газрын хэцүү рүү! Хүний л гарч хүрч болохгүй руу л зүтгэнэ шүү дээ. Тэгэхлээр л энэ рүү буухаасаа гарахад нь боломжтойгоор нь үүгээр гараад энэ их чулуун дундуур нилээд сүлжсэний эцэст тэр ширэнгэ рүү орно гэж мэдээрэй... Сандаг Бор хоёр буцжээ.

- Чононд хавх зүүгээд байж болмоор байна уу?

- Ийм байран газар яаж зүүхийг жаахан төсөөллөө... Сандаг зам зуураасаа,

- Энэ гол руу ороод гаръя гэсэнд Бор дууүгй дагав. Ой модон дунд орж ийш тийш баахан тэнүүчилснээ ойн хэсэг чөлөө олж,

- Энэ юуны мөр вэ? гэж саяхан гүйн өнгөрсөн амьтны мөр асуусанд,

- Үнэг бололтой гэж Бор хэлжээ.

- Цастай болоод мэдэгдэхгүй байна. Үнэгний гүйдэл газар байна. Энд жижиг хавх яг энэ хавьд зүүгээд байхад хэдэн ч хүүхэн лоовуузны арьс бэлэглэнэ дээ. Ичсэн Бор болдогсон бол газар луу шингэчихмээр санагдана.. Бор газры нь сайтар ажиж авав. Энд хавх зүүхэд... гэж яг заасан газры нь зүрхэндээ тэмдэглэв.

- Жижиг үнэг байна. Амьтны мөр, тэр амьтныхаа том жижгийг хэлж өгдөг юм. Бас цас шаварт уг мөр хир зэрэг лав юм уу өнгөц гарснаар тэр амьтныхаа том жижгийг хэлжөгдөг юм. Бас цас шаварт уг мөр хир зэрэг лав юм уу өнгөц гарснаар тэр амьтны том жижгийг мэдэж болно. Хөлөө хир зайтай тавьснаар нь ч том жижгий нь мэдэж олно. Ижил мөр их ховор байдаг юм. Хурц нүдтэй хүнд бол үнэгний арван мөр тохиолдоход арван л янз байдаг юм. Худлаа гэвэл чи хэрэг болгоод хэмжээд үзээрэй. Залуу хүн ганцхан юм агнах гэж цагаа сүйтгэж байснаас юм юм оролдож явахад зүгээр шүү. Бор дахин царай минчийн улайв.

Харих замын турш Сандаг Борд газар орны байдал, ан гөрөөний тухай ярьсаар явав.

- Хавхаа хэзээ эргэх вэ? гэж Бор асуусанд,

- Барьсан, унагасан амьтнаа идэж амжаагүй чоно хоргодогтой байдаг. Түүнийг сахиж чадвал ганзагандаа юмтай л байх. Гэвч энэ бол жирийн чонын идэх гэсэн ав гөрөө биш, дийлддэггүй дайснаа дарсан тэрхүү сүрэг чонын бахаа хангасан "ялалт" болохоор ирэхгүй байж болох зүйл. Тэгэхдээ чононд хоол ховордсон цаг болохоор эд заавал ирнэ. Маргааш чи ганцаараа ирж эргэ! За даа маргаашдаа юу л ирээ аж. Ганц нэг жижиг чоно холхнуур тойрсон байж болно. Тэгэхдээ чи, хавх хөдөлсөн эсэх нь хаанаас харагдана гэлээ. Яг тэр газраас хараад бушуухан буц гэжээ. Маргааш нь Бор хавхаа эргэжээ. Нээрээ нэгэн жижиг чоно тойрон явсан мөр гарчээ. Энэ бол дэлт саарлын сүргийн туршуул...

Нөгөөдөр нь Бор бас явав. Нилээд хэдэн чоно их ойрхон ирээд сууж, мөн хөөцөлдөж ноцолдсон бололтой цасан дээр унаж туссан гараад буцжээ. Энэ бол бэлдсэн үүцээ ханзлахын өмнөх чонын баяр. Хавх эргэхээр явуулахдаа Борд хэлдэг Сандаг өвгөний үг, Борын хавх эргэхдээ үзсэн чонын мөрийн байдал хоёр яг тохирч байдаг нь Борыг өөрийн эрхгүй Сандагт бишрэхэд хүргэв.

Сандаг насаараа мал малласан хүн. Түүнийхээ хажуугаар намаршихаар цөөн тарвага агнадаг, бүр намар орой гахай жаахан хөөцөлддөг л хүн. Чонын анд зориуд бараг явж үзээгүй. Гэхдээ чоно дайралдахад алдаж яваагүй. Дэлт саарал бийг мэднэ. Түүнтэй ер нь дайралдсангүй. Мөрий нь үзсэн. Энэ хавьд ганцхан байгааг ч мэднэ. Ганц юмтай хөөцөлдөх гэж огт бодсонгүй. Гэртээ эхнэртэйгээ, охин Дулмаатайгаа гурвуулхнаа. Охин нь эрдэм номын мөр хөөж базаасангүй. Харин сүү сааль, үйл оёдолд муугүй. Охин нь Бортой сайн болсныг мэдээд жил тойрчээ. Бороос сайн хүү ганц нэг байсан нь цэрэг сургууль гээд алга болов. Тэгэхээр Бортой явал ч яаг гэж бодох болжээ. Борд нэг л болохгүй юм байна гэж Сандаг бодно. Тэр нь юу вэ? гэвэл жаахан хөнгөндүү ажээ. Эр хүн элдэвтэй гэгчээр юм юманд хүрэмтгий байгаасай гэхэд тун ч хөдөлж өгдөггүй нь жаахан гонсойлгоно. Бор Дулмаа хоёр өөр бас нэг юманд хорхойтой болгочих юмсан гэж Сандаг өвгөн боддог болсон тэр үед хул азарга чононд унагуулжээ. Энэ гэнэдлий нь дайруулаад ангийн мөр лүү оруулах гээд нэг үзвэл яах бол?! гэж бодохдоо туршихаар шийджээ. Бор хоёр өдрийн хавх эргэлтэнд дуртай явжээ. Дэлт саарлаас хариугаа авахсан гэж нэг л бодоод байх болжээ.

*Суудаг дүнжин гүйдэлтэй*

*Суман голтой халиун*

*Сургаал тавин суугч*

*Аав ээжий хоёр*

*Хажуу дүнжин гүйдэлтэй*

*Хар голтой халиун*

*Харуул тавин суугч*

*Ах дүү хоёр*

*(Дулмаагийн дуртай дуунаас)*

Дулмаа орондоо ороод хэвтэж байтал Бор орж ирэв. Дулмаа хөнжлийнхөө сэжүүрийг толгой дээгүүрээ бүтээчихэв. Хул азарга эндсэнээс хойш дөрөв дэх шөнө болж байгаа нь энэ. Гурав дахь оройгоо Бор орж ирж байгаа нь энэ. Сүүлийн гурван оройн нэг дэх орой орж ирэхэд нь Сандаг,

- Маргааш, хавхаа холхноос зүгээр ажих маягаар эргэ. Ганц нэг л чоно тойрон гүйсэн байж мэднэ... гэж хэлсэн. Тэр яг тийм л байсан. Хоёр дахь орой орж ирэхэд нь маргааш хавхаа мөн тэр хавиасаа эргэ! Нилээн хэдэн чоно ирсэн байх бий. Гэвч хул азарганд ойртоогүй байх бий гэсэн... тэр ч бас тийм байсан. Өнөө орой Борыг орж ирэхэд,

- Маргааш чи эртхэн яв! Дэлт саарал ирсэн байж мэднэ. Ер нь ирж үү, үгүй юү гэдгийг мэдэхийн тул мөр сайн мөшгөнө шүү. Дэлт саарлын мөр ямар андаш байх биш! Олон чонын мөр дотор би ганцаараа гээд л дурайж байх бий. Юм яаж мэдэх вэ. Чи маргааш буутай яв гээд Сандаг буугаа өгчээ. Харин Борын хувьд яаж буудахыг заалгах хэрэггүй байв. Бор өөртөө буугүй болохоос биш юм буудаж чадна. Сандаг бас дэлт саарлын хаанаас ирэх, хаагуур яаж яаж, аль хадан дээр сууж, буцаж яаж буугаад хаагуур доош орж, яаж газар харайн буухыг Борд нэгд нэгэнгүй хэлж өгсөн болохоор яг л өөрийнхөө хэлж өгснөөрөө хянаж харахыг Борд захижээ. Сандаг бас Дэлт саарал хэрэв хавх аваад явсан бол араас нь битгий яв! Догшин хилэгнэсэн араатан үхэх амьдрахын зааг дээр газрын хаанаас ч гэнэт гарч ирээд чам шиг гэнэн гэгэлгэр эрийг яаж ч мэднэ. Тэгэхээр хавх аваад явсан бол бушуухан буцаж ирж хэл бол гэдгийг хүртэл захив. Эцгийнхээ ингэж захиж байхыг Дулмаа яг сайхан сонсож байв. Эцгийн нь сүүлчийн захиас үг Дулмаад их аймшигтай санагдав. Бор нь одоо л дэлт сааралтай үзэлцэх гээд явах гэж байгаа юм шиг санагдав. Хөнжилдөө шургасан ба аймшигтай үг сонссон хоёроос болоод зүрх нь цохилон амьсгаа бачуудан байвч Дулмаа яаж ч чадахгүй хэвтэв.

- За ингээд явж үз! Маргааш дэлт саарал хавханд эс суух юмаа гэхэд нөгөөдөр ч лаваа! гэж

Сандаг хэлэхэд Дулмаагийн амьсгаа жаал уужрав.

Бор, Дулмаа руу нүднийхээ булангаар харав. Дулмаагийн амьсгаа түүнд мэдэгдэж байв. Бор өнөө орой, түрүүчийн хоёр оройг бодвол бүүр шөнө орой болсон хойно ирсэн юм шүү. Бор "Шөнө орой болчихож, эндээ унтаад яв!" гэж Сандагийг хэлэх ч бол уу гэж бас горьдов. Үнэндээ ч тийм бодолтой ч ирсэн юм. Гэвч Сандаг нүүр өгөхгүй байв. Борыг гарах гэж байх үед эмгэн Сандагийн сүвээний зузаан махан дээр халуу оргитол чимхэв. Сандаг цочиж,

- Ёо ёо, чи яав! Гээд уурлан эргэх үед Бор гараад явчихав.

- Энэ шөнө болчихсон хойно түүнийг тас харанхуй тэсгэм хүйтэн хоёр дундуур явуулах чинь юу вэ! Унтаад өглөө л явна биз. Хүүхдийн хэрэг чамд падтай юм бэ? гэсэнд,

- Цаг нь болоогүй байхад хүүхдийг битгий цадиг алдуулж бай. Айх ичих, ах захын ёс гэдэг чинь хэнд ч хэрэгтэй юм... гэж Сандаг өгүүлжээ.

Гэрт гэрэл унтрав. Дулмаа хөнжлөө доош болгов. Гэгээгүй гэрт сэрүүхэн байв. Дулмаа эцэгтээ бага зэрэг гоморхож Борыгоо өрөвдөн хайрлах санаа төрөв.

Дулмаа Борыгоо санаашран хэвтэв. Аав нь үгүй байгаад өвөл бишсэн бол Борынхоо араас босон одоход ч бэлэн байв. Хул азарга чононд унагуулсны төлөө энэ хэдэн өдөр тэр хичнээн хүнд нүдээ чичлүүлж байна вэ? Зарим нь хууль дүрэм заан загнана. Зарим нь өчнөөн төчнөөн өр төлбөр дурдан омогдоно. Зарим нь залхуу хойрго, санаатай санамсаргүйд нь хүрэн давшилна. Үеийн нөхдийн зарим нь тоншуул юм уу сонинд бичиж олноороо хэлэлцэх хэрэг болговол зохино гэнэ. Борын аав ч бас хүүгээ арга хэмжээ авбал аваг гэж байх шиг байна. Борын тухайд олны ам хааш эргэхийн учры нь олохгүй харж буй хоёр хүн гэвэл Дулмаа, түүний эжий хоёр л бололтой.

Дулмаад Бороос нь хайртай хүн одоо дэлхий дээр алга. Хаашдаа л Бортойгоо л дүүрнэ гэж шийдсэнээс хойш түүнийгээ өрөвдөн хайрлахгүй бол юугаа ч хайрлах сан билээ. Түрүүн Бордоо нэг удаа дэмий л үг хэлсэндээ тэр одоо амаа барьж байна. Дулмаа яагаад Борд хайр сэтгэлтэй болчихсон бэ? гэвэл, ноднин зун Дулмаа үнээний ферм дээр сааль сааж байгаад гэнэт ухаан алдаж хавь ойрд эмч ч байхгүй, ер юу юу ч байхгүй бөөн үймээн шуугиан болж байхад гагцхүү Бор нь эр чадал зааж өчнөөн газрын холд түүнийг эмнэлэгт мориор хүргэж амий нь аварсан учир Дулмаа түүнд марташгүй их баярлажээ. Дулмаагийн амий нь аварсан энэ тохиол түүнийг улмаар хайрлах хайрын үндэс болжээ. Ер нь нэг сайхан чанар гэвэл хэдий хөнгөндүү зантай ч гэсэн хэн ядарсан хүнд хэдийд ч гэсэн чадал хүрвэл тус болох гэж байдаг юм...

Дулмаа дахин Борынхоо хойноос сэтгэл тавив. Өөрвөө хамт явахгүй, түүнийг ганцаарангий нь юунд явуулна вэ! Дэлт саарал гэдэг тийм амархан араатан гэж үү гэж бодов.

## Зургаа. Бор

*Алдартыгаа алдсанаас хойш, бусад сүрэг нь*

*нутаг буруулан одоод дахин огт үзэгдэхгүй болжээ...*

Маргааш нь Бор, Сандагийн хэлсэн ёсоор өглөө эртлэн мордов. Тэгэхдээ тэр Сандаг чухам яагаад эрт яв гэсний учрыг ойлгосонгүй билээ. Хул азаргын унасан газрыг хүртэл Борын сэтгэлд элдэв бодол эргэлдэж явлаа. Дэлт саарал хавханд орж хавхаа аваад явсан байвал яах вэ! Араас нь явах уу. Сандагийн хэлсэнээр бушуухан хэл хүргээд буцах уу! Хавх хөдөлсөн эсэх нь харагддаг тэмдэгт газар дөхөн очтол цасан дээгүүр гүйсэн чонын эржгэр цоохор мөрийн хажууд дэлт саарлын аяганы ам шиг том мөр гарсан байхад нь Бор цочихдоо могойноос айдаг хүн шиг мориныхоо жолоог хажуу тийш эргүүлэх шахав. Дэлт саарлын мөрөөс тэр чонын дүр харагдах шиг болдог. Амьтны мөр уг амьтныхаа том жижгийн хэмжүүр болдог гэдэг. Дэлт саарал Борд тэмээ шиг амьтан байхаар дүрслэгдэв. Тэмээ шиг тэр амьтаны дөрвөн хөлд дөрвөн хавх орлоо ч гэсэн уг хавх маань түүний амин газар нь орсон ганц сумны төдий зүйл биш тул дэлт саарал хавхаа харжигнуулсаар баавгай шиг архиран хүрч ирж болмоор санагдав. Дэлт саарал яг л Сандагийн хэлсэн газраас иржээ. Яг л өнөө ширээ хадан дээр гарч "тухалжээ". Буцаж мөн бууснаа эргээд арай зүүгээр нь одож жаахан доошлоод нээрээ л хариагаад газар буухдаа яг гол том хавхан дээр суужээ. Том хар хавханд цохиулсан уурандаа болж үсчиж цовхчин урагш хойш болохдоо бас хоёр хавханд цохиулжээ. Ингээд гурван хавх аван Сандагийн хэлсэн газраар оджээ. Буугаа яг бэлдээд дэлт саарлын араас мөрдөж жаахан харъя гэж бодоод Сандагийн зааж хэлсэн том чулуунуудыг нэгжин нэхэн явав. Дэлт саарал энд тэнд хад чулуунд хавхаа савж цохисонч байх шиг мод чулуунд тээгэлдүүлээд үсэрч цовхчсон ч байх шиг. Заримдаа гань галзуу амьтан яваа мэт дуулгаварт сүрэг нь түүндээ тус хүргэх гэж урд хойно нь орж унан тусан гүйлдэхэд дэлт саарал уур омогтой болж хоёр том азарган чоныг барьж үнгэн хоолойг нь тас хазан алж хаясныг үзэв. Хоёрын хоёр азарган чоноо бариулсанаас хойш бусад чоно нь дэлт сааралаас зүрх алдан аяндаа холуурхан дагаж эхэлжээ.

Гурван хөлдөө хүнд төмөр хавх өлгөчихөөд хоёр том чонын хоолой таслан хаясныг бодоход дэлт саарал юутай хүчирхэг дошгин араатан болох нь мэдэгдэж байна. Ийм араатан надруу гэнэт дайрвал би яах вэ! Амжиж л эхний сумыг амин газарт нь өгөх хэрэгтэй эс тэгвэл морьтой биетэйгээ хүүршин нэхий шиг тасар татуулна. Бор эрэлдээ бас дасаж байна. Газрын байдал улам бартаа ихтэй болж байна. Хад чулуутай газар дуусаж бөөн ширэнгэн ойтой газар болох нь. Модруу орж баахан явсанаа буцжээ. Гөрөөс шиг шургачин сүлжиж барсангүй. Сүрэг нь мөн холуур дагаж гүйлдсээр л байжээ. Гэтэл аянганд ниргүүлж ойчсон лужир том хар мод ямар нэгэн уртын урт биетэй хар амьтан шиг өч дөчнөөн модыг хуга суга цохин дарж, дамнан хэвтээ нь харагдав. Энэ модны хаагуур нь ч гэтлэн гарсан байж таарамгүй байлтай. Морь нь чихээ сортолзуулан хамраа тас хийлгэн уухирдав. Хөндөлдөн хэвтээ их хар модны үзүүр талын нь барьс хийгээд тойрон явав. Дэлт саарал цааш явсан мөр алга. Харин хажуугийн хар довцог дээр сүрэг нь зүг зүг харан суусан бололтой ор мөр байна. Зүг зүг рүү харан нуруу нийлүүлэн суусан бол дэлт сааралдаа учирсан гай зовлонг яах билээ гэж түүнийг



хайрлан өмөөрч баахан улин хуцан шуугиад эцэст "Ээ дэлт сааралаа бид өөрт чинь ямар ч тус хүргэж чадахгүй нь. Бас тантайгаа цуг ингээд үхэлтэй биш. Бид зүг зүг өөр өөрсдийн амийг тээн одохоос доо. Олон жил омог сүр хараа бараанд чинь амар сайхан явлаа. Одоо бидний аз дугааж бид үүрд хагацан салах болов. Бид дор бүрнээ хаа хэдийд үхэн хатан дуустлаа их саарал чиний ач тусыг дурсан санаж, их саарал чиний өшөөг авч явах болно " хэмээн бас баахан ганганалдаж гунганалдаа байх даа..." гэж Бор бодлоо.

Чонууд хар довцгоос бууж тэрхүү сунан унасан хар модыг тойрон баахан эргэлдэж байснаа аргагүйдэж ганц нэгээр зүг зүг уван цуван оджээ. Бор, хар модны үндэс ёзоортойгоо сөнгөрөн (ховхорон) ойчсон нь томоо ханан хар эрэг шиг харлан харагдаж буй руу ойртов. Тэрхүү ухагдсан тогоо шиг хар нүхэнд дэлт саарал ороод гарчээ. Гараад хар модны доогуур шурган орсон бололтой. Түүний хэвтэж буюу чухам яаж байгааг харах гэж мяраан явсаар гэнэтхэн тэмээний толгой шиг зантгар толгой харагдахад Борын айсан нь тоймгүй. Борын нүдийг нулимс бүрхжээ. Толгой нь ийм байгаа юм чинь яавч Дондовын хар буурнаас багагүй эд байх нь гэж санав. Ийм лут томдоо л хул азаргыг энэ золиг хул азаргыг минь дөнгөжээ. Түүнээс биш манай хул азарга хэр баргийн амьтанд дийлдэх амьтан биш шүү дээ гэж бодов. Харсан хүн бүгд л үүнийг "томоо том... Ээ дээ амбан шар л гэсэн үг " гээд л зүйрлэх үгээ олж ядаад байдаг нь бас ч аргагүй юм байна гэж мөн бодов. Энэ уул нь жижиг чоно байсан байх бусдыгаа барьж идсээр байгаад ганцаараа ингэж томорч үлдээ бол уу ч гэж бодов. Дэлт саарал Борын ирэхийг эрт мэджээ. Чонын гурван найдвар гэж байдаг. Чих нь түүний нэг найдвар мөн. Хүйтэн, цастай цагт чоно хүний болон малын хөлийн чимээг их алсаас сонсоно шүү дээ. Тэр дундаа үхэх үйл нь ирсэн араатан улаан голын нь таслах учрааныхаа хөлийн чимээг бүр ч алсаас сонсоно шүү дээ. Чоно өөрийн дайсанд зүв зүгээр бууж өгөхгүй! Ёстой л эцсээ хүртэл үзэлцэх цаг ирснийг мэдлээ. Гурван мөчий нь тэсэж тогтохын эрхгүй болтол хавчин шаналгаж байгаа хавхны зовлонг бодох тусам, тэр хүнтэй үзэлцэх гэж улам улмаар улангасан байж ядаж байв. Заримдаа дэлт саарал амин голын нь таслах шахан байж ядаж байгаа хавхны халуун шаналгаа огоорон мартаж, ёстой тарчилган шаналгагч нь сая толгойгоо цухас хийлгээд далд орсон хүн учраас тэр хүнтэй л үзэлцэх мөчийг байж ядан хүлээнэ. Бор амьдралдаа анх удаа ийм аварга том чоно харж байгаа болохоор айх гайхах хослон, яах вэ гэдэг бодолд янз бүрээр умбана. Сайтар чагнавал чонын цээж цан хүүрэг болсон модыг чичрэн салгантал хүржигнээд ч байх шиг. Адгуус, араатны араншинг хүнээс урьд мэднэ.

Бор морио харвал морь нь айж чичрэн, байж ядахдаа байн байн шээс алдаж дагжаад байх шиг. Морио тэр уяж чөдөрлөхгүй сул орхижээ. Мориноос салахад яах вэ, дэлт саарлыг л нухсан байвал л гүйцээ тэгэхдээ би дэлт саарлыг нухаж чадах уу гэж Бор өөрөөсөө дахин дахин асуусан юм. Чоно хавханд оржээ гэж Сандагт очиж хэлэх ч хариугүй дорой л эрийн шинж ээ дээ. Очиж хэлэх хүн маань хадам маань болох гэж байгаа хүн шүү дээ. Хадам маань миний эр чадлыг шалгах гэж байхад, би түүнээс өмгөөлөл эрж очих яасан ичихэвтэр хэрэг вэ! Хөлдөө гурван хавхтай чоно гэдэг чинь үнэндээ гурван мөчийг нь бариад уячихсан амьтан шүү дээ. Тийм амьтныг нухаж чадахгүй бол юуны эр хүн байх вэ! Гэвч энэ маань жирийн нэг чоно биш манай энд байгаа дэлт чоно гэгдсэн хамгийн том чоно шүү дээ. Ном сударт өгүүлдэг жинхэнэ дэлт чоно мөн үү, бус уу, бүү мэд! Тэгэхдээ л энэ бол тэр дэлт чонын төрөл мөн . Манай энд буй хамгийн том чоно мөн. Манай энд байсан хамгийн аюултай, хамгийн том чонын сүүлчийг Содовийн Бор буюу Хангайн Бор гэж манайхан нэрлэдэг Бор

маань нухлаа шүү дээ. Бид ч Бордоо дэмий Хангайн Бор гэж нэр өгөөгүй байна шүү гэж хүмүүс хожим хэлэлцвэл мөн аятай яа гэж Бор бас бодлоо. Бор Дулмаагаа дурсав дэлт саарлыг нухчихаад очвол Дулмаа маань яасан их баярлах бол. Чи ч хул азаргынхаа хариуг авсан шүү авлаа. Хүмүүс одоо чамайг хүний гэр хариулдаг гэхгүй, хөлтэй бэлтэй анчин гэнэ дээ. Нутгийн залуучууд чамайг хүндлэн үзэх болно гэх байх даа гэж бодов. Бор бодсоор дэлт саарлыг унагая гэж шийдэв. Хад чулуу халхлан явсаар хоёр чулууны завсараар цухуйн харвал дэлт саарал түүний хаа явааг яг мэдэж байх ажээ.

Одоо тэр хоёр чулууны завсараар намайг харна гэдгийг дэлт саарал хэдийн мэдчихсэн, мөн л өөрийн нь түрүүлээд харж байгаа Бор бас л доошоогоо бултас хийн суув.

"Яасан айхтар гайхал вэ! Ядахдаа морьлуу ч хардаггүй байна шүү. Адгуус хэзээ ч араатанд халдадгүй гэж боддог болохоороо миний муу морийг даанч юман чинээ бодохгүй байх шив дээ. Адгуус ан дотор дийлдэггүй нь л хул азарга маань байсан. Одоо түүнийг унагаж авсан болохоор, ондоо миний амь насанд гай барцад учруулах адгуус энэ хавийн хангайн нутагт байхгүй гэдгийг дэлт саарал ёстой нэг мэдэж байх шив дээ..." гэж Бор бодов.

Бор цааш нь цасан дээгүүр улаан нүүрээрээ шүргэх шахуу мөлхөн бас байр солив. Өөртөө бол яагаад ч дэлт сааралд мэдэгдэхгүй гэж санасан намхан бутны ёроолд хүрэв. Толгой жаахан өндийлгөж тэр бутны сиймхийгээр яаж дэлт саарлыг олж харна даа гэж зай завсар эрэн хайсаар арай чуу хэмээн өчүүхэн чөлөөгөөр хартал дэлт саарал бас л Борыг харсан байх ажээ. Газрын байдлыг харвал дэлт саарал улам улмаар ойртсоор байна. Гэвч дэлт саарлыг хөдөлгөхгүй дор нь нам унагах боломжийн газар хүрсэн үү гэвэл арай ч болоогүй юм шиг. Дандаа л нэг тийш мөлхөөд байгаа болохоор дэлт саарал мэдээд байгаа байх. Тэгвэл зүгээ өөрчлөөд, эргээд зүүн хойш нь аятай мөлхвөл яасан юм бэ гээд газрын байдал харвал боломжийн газар байна.

"Тэр нэг түймэр идсэн хар ховлийн ёроолд хүрдэг хэрэг " гээд мөлхөв. Бор, хар ховолд хүрэн хүртлээ нилээд мунгинав. Газар нь тийм ч шулуухан хүрчих газар биш байж. Гурван хөлдөө хавхтай араатанг унагаж болох вий гэхээс өөр юм түүнд бодогдохгүй байна. Тэгснээ "Дэлт саарал яагаад хөдлөхгүй хэвтээд байна вэ? Хул азаргын сүнс нэхэн ирэх хүнтэй ширүүн мэтгээн хийхээр хөлдөө зуурсан хавхнуудыг салгах гэж ноцолдоод байгаа юм биш биз дээ" гэх бодол төрөв... Бас "...Үгүй биз! Дэлт саарал энэ тэр юмыг оролдохгүй, зүгээр л юу ч болоогүй юм шиг хэвтээд байна шүү дээ яахаараа ингэдэг билээ? Сандаг гуайн хэлсэн, баавгай тэвэрсэн ч тавихгүй гэсэн хар хавхы нь нарим буулгаж хаячихаад, намайгаа сайн ойртуулж байгаад ганцхан үсрэхдээ л улаан нүүрэн дээр минь буугаад ёстой л Сандаг гуайн хар хавх шиг тас тэврэх гэж байгаа юм биш биз дээ" гэж бодмогц Борын биеийг хий айдас хүйтэн могой ороох шиг болов. Бор, хар ховлын хажуугаар толгойгоо үл ажигдам өндийлгөсөөр дэлт саарлыг харвал бас л өөрийг нь харчихсан байх ажээ. Бор мөн л доошоогоо нам болов. "Энэ чинь яасан айхавтар араатан бэ? Ёстой л далдыг хардаг увдистай байх. Нутгийн анчид үүнд халддаггүй нь энэхүү ид увдисаас нь болдог байх" гэж бодов. Үнэнийг хэлэхэд гурван хөлдөө голыг нь гогдох шахсан шаналгаатай хавхтай араатанд юуны тийм эд увдис байх билээ. Ний нуугүй хэлэхэд энд дэлт саарал эд шидтэй биш. Харин Борын анч гөрөөч туршлага дутаад байгаа юм. Өвөл цаг гэдэг юм юм хамгийн их анир чимээтэй байдаг цаг билээ. Мөчир хугарсан ч аниртай, мөс хэмхэрсэн ч чимээтэй. Бор өөрөө цасан

дээгүүр анир чимээгүй мөлхөж байна гэж бодож байгаа. Гэвч Борын мөлхөхдөө үүсгэж байгаа чимээг дэлт саарал, Бороос илүү содон соргог сонсож байгаа юм. Яагаад вэ? гэвэл дэлт саарлын хувь заяа ийм анир чимээтэй холбоотой билээ. Өвөл цагийн өдий зэргийн анир чимээг дэлт саарал хоёр чих нь бөглөрсөн байсан ч гэсэн газартай холбоотой биеэрээ мэдрэх боломжтой биш үү. Өнөөдрийн хувьд дэлт саарлын ийм сонор байгаа нь түүнийг тэсэхүйеэ бэрх шаналгаж байгаа хавхны, цаг өнгөрөх тусам улам нэмж буй зовлон, түүний араас амий нь авахаар хүн заавал ирнэ гэхээс яахаа ч мэдэхгүй байгаа аюумшиг хоёр билээ. Чоно хичнээн том тусмаа төдий чинээн том мөртэй байдаг. Бас мөр нь хичнээн том тусмаа газарт үлдээх хээ хэмжээ нь төдий чинээ тод томруун байдаг гэж дээр өгүүлсэн билээ. Чоно хэдий чинээ хашир хартай тусмаа, газар дэлхий дээр мөрнийхөө хээг төдий чинээ гаргахгүй явах гэдэг. Тиймээс чоно хаагуураа явах байтугай хаана хөлөө тавивал аминд хал балгүйгээ ч мэддэг гэдэг. Гэтэл энэ өвөл, энэ шинэ цас, гурван мөчийг нь тас тэвэрсэн хар хавх дэлт саарлыг энэ дэлхий дээр даанч нуугдуулах эрхгүй болгож дээ.

Дэлт саарлын байдлыг бодох тутам Сандаг өвгөн юу гэж хэлдэг захидаг байсан нь Борд бодогдоно. Тэр ч байтугай жирийн нэгэн бор бааз гөрөөчин биш, их ухаалаг, үлэмж туршлагатай анчин гэдэг нь мэдэгдэнэ. Сандаг өвгөн шиг ан амьтны амьдрал аж төрөх байдал, аранш төрхийг мэддэг бол өөрийгөө анчин гэхэд нүүр улайлгахгүйсэн. Сандаг шиг гөрөөч болоход их мэриймж хэрэгтэй. Гэвч мэриймж зүгээр олдохгүй. Одоо ингээд л мэтгэж мэрийхэд Борд хожимдсон огт үгүй. Хамгийн гол нь Сандаг өвгөнийг ан гөрөөний цагаар сүүдэр шиг уйгагүй дагахад өвгөний нэг насны эрдэм чадлыг өөртөө шингээн авах бүх боломж байна.

Бор буцаад баруун хойш чигтээ яльгүй газар байр солив. Энэ удаад өндийж харах гэсэнгүй. Эргээд зүүн хойш, тэгснээ шууд дэлт саарал руу мөлхөн, нэгэн нөмрөг хадны ёроолд очив. Ингэж хэдэн тийш байр соливол дэлт саарал намайг хаана байгааг мэдэхгүй будлих болов уу гэж тэр горилжээ. Буурал цан болсон өвс дэрсний үл ялиг хөдлөх, хөвсгөр цас мөчир гишүүний үзүүрээс унах төдийгөөр Борын хаана явааг мэдэж байгаа араатан энүүхэнд хөдлөх гэж яахыг хэлэх вэ?

Хар... хар санааны хүчинд хар хамарт амьд явдаг гэдэг яасан үнэн үг вэ! Хамар, чих, нүд гурав чонын гурван сүнс аргагүй мөн юм. Бор амьсгаагаа дарж жаахан азнаж байгаад харвал дэлт саарал бас л харж байв. Бор "Энэ муу дэлт саарал намайг яагаад хараад байна вэ? Би өвлийн айхалж амьсгаадсан амьтан шиг тийм их уур цан татуулаад байна уу?" гээд өөрийгөө ажвал энгэр заам, малгай хөмсөг, дух дээгүүр нь нээрээ бужгар цан тогтжээ. Дэлт сааралд нэг хүний уур амьсгаа гэдэг бяцхан горхийн уур цан шиг харагдахгүй яах вэ, хүмүүс зарим нь чоныг манантсан хөх нүдтэй гэдэг. Гэвч чоныг үзээгүй боловч, насан турш чоно...чоно... гэж хүний ярихыг чихээ хумайтал сонссон хүмүүс чоныг жартгай улаан нүдтэй гэдэг. Зарим нь чонын ам идсэн ч улаан, эс идсэн ч улаан гэдэг. Энэ бол харин онож хэлсэн үг биш үү! Тэгээд чонын нүд чухам ямар вэ? гэвэл миний хувьд бараг л хуван шар буюу цэнхэр шар гэмээр байх юм. Бор, газрын барагцааг үзвэл дэлт сааралд ихэд ойртжээ. Одоо түүний өмнө нэгэн арсгар чулуу харагдана. Тэнд хүрвэл цааш явах газаргүй болжээ. Ер нь ч түүнээс илүү ойртохын ч хэрэггүй билээ. Яагаад вэ гэвэл дэлт саарлыг буудах гэж яваа болохоос биш барилдах гээүгй билээ. Мөлхөөд арсгар чулууныхаа ард хүрэв. Харвал дэлт саарал хавхаа харжигнуулнаднийж байв. Урагшлаад хүрэх газаргүй зугтаад ч гарах газаргүй болно гэдэг

энэ байжээ. Дэлт саарал тун их аазгай нь хүрч байх шиг байна. Аль түрүүнээс хойш Борын дамшиглахыг харсаар тэвчээр нь барагдсан бололтой. Хавх харжигнах гэдэг дэлт саарал хавхаа мулт цохиж чадаагүйн тэмдэг. Бор, дэлт саарлыг жоохон ажиг. Дэлт саарал бие нь ч тун шаналгаа зовлонтой байх бололтой. Ёстой л шархны халуун болж байгаа бололтой. Хэвтэж ч болохгүй, сууж ч болохгүй, явж ч болохгүй яаж ч болохгүй үе гэж байдаг бол тэр л болж байгаа бололтой. Дэлт саарлын санаа бол ганцхан үсрээд Борын хоолойг тас хазан үхэвч түүнтэй хамт үхэх гэж мэрийж байж болох юм.

Буудах гэтэл газар эвгүй мэт. Буудаад хэрэв амин газрын нь онохгүй бол дэлт саарал хавхтайгаа үсрээд ирэхэд газар ойрхон, хамгийн гол нь түүний хавхтай хөлд тээр болох газаргүй тул байраа сольж баруун талд нь байгаа бөөн чулуун дунд орж түүнийг түших нь хэрэгтэй болов. Бор тэрхүү бөөн чулууны түшиг бараадав. Ийм асар их арсгар барсгар хадан дотроос нэгэн ширхэг харлаг тэх гэдэг дэлдгэр саарал огтоныг барих бэрхтэйн адил, дэлт саарал ч энэ чулуун саадыг ч хавх харжгануулан туулж Борыг базах гэдэг нь бас тийм хялбар биш болох нь тэр.

"...Чоно адгууснаас өшөөгөө авч байхад, хүн араатнаас өшөөгөө авч бололгүй яах вэ" гэж Сандаг өвгөний хэлсэн санаанд оров.

Бор, дэлт саарлыг буудаж болох халх хадны ард суув. Дэлт саарал аюул нүүрлэн ирснийг мэдсэн бололтой амаа ангайн гаслаж үзэгдэв. Дүн өвлийн хүйтэнд, араатан халуун цагийнх мэт ам ангайн гаслах гэдэг шархны халуунд нэрвэгдэж тэсэхүйеэ бэрхэдсэний тэмдэг билээ. Залуу чонын шүд хурц гэвч хөгшин чонын шүд хэнзлэхдээ сайн гэдэг үг байдаг. Дэлт саарлын ам өдий хүртэл хичнээн амьтны аминд хүрээ бол гэж санахад гайхалтай тоо гармаар санагджээ. Нэг чоно жилд гурван тонн орчим мах иддэг гэж сонссон ч шиг. Гурван тонн махыг мал болгохоор бүр ч аймшигтай тоо гармаар болохоор тэр бодлоо орхив.

Бор, биеэ айв тайван байлгаж буюгаа шагайх гэсэнд зүрх нь түг түг цохилоод дэлт саарлын амин газрыг олохгүй, хараалсан газрын нь хааж аяганы ам шиг цацарсан шар туяа татаад огт болсонгүй. Нүднийхээ харааг шалгаж нүдээ аньж харж баахан үзэв. Нүдээ арчиж ч үзэв. Дахин буюгаа шагайх гэтэл дэлт саарал цаашаа модны ёроол руу шигдэж нуугдах гэтэл хавх нь юманд тээгэлдэж чангаасанд уурлан хорсов бололтой шархтай хөл буюу хавхтайгаа цас манарган ноцолдож гарав. Мод мөчир хугарч цас шороо манаран чонын аймшигтай гаслан уурлан ноцох авиагаар морь нь бас мод чулуу пижигнүүлэн давхин одов. Дэлт саарал бахдаж ядсан уур хорсолдоо болж нэгэн хөлөө хавхнаас салгажээ. Одоо түүний нэг талын хойд өмнө хоёр хөл суларчээ. Дэлт саарал Борлуу дайрахаар санаа шулуудав бололтой оромж нүхнээсээ өндийж бүх биеийн гурваны хоёр хувь ил гарч, цээжин тал нь аятайхан хөндөлсөөд ирэхэд Бор улаан сугын нь барин гохоо дарчихав. Дэлт саарал далд байсан бөгсөн биеэрээ годройтон савагдаж тас гэдэргээ савж ойчоод хавхтай хөл талаараа босч чадахгүй баахан сарвалзан тийчилснээ арай л чуу гэж бие ээ татаж гаслан босоод ирэв. Алджээ. Амин газрын нь олсонгүй. Дэлт саарал галзууран шууд өөрий нь чиглэн харайж эхлэхэд нь Бор гүйдэл дунд нь хоёрдахиа буудав. Чоноос айх хэрэггүй араатан, хүний айн хэрдхийхийг анддаггүй. Харин хүний сүрийг үзүүлж чадвал араатан өөрийн эрхгүй сүр сүлд нь унан хүнийг харах чадалгүй болж амиа хаацайлан буруулна гэдэг. Хоёр дахь удаагийн буудалтанд дэлт саарлын хавхтай нь тас хазаж хаясан зүүн өмнө талын мухар хөлтэй хаа суга буудагджээ. Тэгэхэд дэлт саарал мөн

л урагшаагаа савагдаж, хунгарласан их цасан дунд хутгалдан цээж хүржигнүүлэн нөгөө том хар хавхтай баруун өмнө талын хөлөө хар- р- р яр- р- р хэмлэн агаад мөн тас хазаж гагцхүү хойт талын нэг хөлд нэгэн жижиг хавхтай болоод өмнө талын нэг мухар хөл нөгөө талын тас буудагдсан хаа хоёрыг үл хайхран хар эрчээрээ харван өмнөх хадан чулуун саадыг яаж давахаараа тийнхүү нисэх мэт давсныг бүү мэд, нэг мэдэхэд яг Борын халхалж байсан чулуу өөд зүтгэн бууны нь амнаас хар- р- р хэмээн зууран авгал Бор бууныхаа гоxyzг дарчихсанд дэлт саарал хамраараа бололтой нэгэн муухай амьсгаа татан гаслаад хойшоо гулдайн ойчжээ. Өмнө талын нь чулууг тэврэх гээд тэнхэл хүрэхгүй, их элс өөд авирсан амьтан элстэйгээ буцаж нурах мэт гулдайн ойчих нь Хангайн Бор хүүд, нутгийн олныг донсолгон байсан дэлт чонын сүргийн сүүлч болох дэлт саарал үүрд унасан нь тэр байжээ.

Борд, дэлт саарлын өмнө хоёр хөл давж ирээд буцсан чулуун дээгүүр өнгийн харахад хоёр цэхэр нүд нь хөдөлгөөнгүй ч гэсэн хараатай харагдахад аазгай хүрчээ. Хоёр нүдээ хараастай үхнэ гэдэг бас л дэлт саарлын эрэлхэг омголонгийн шинж гэж Бор бодлоо. Гурван хөлдөө хавхтай байсан... Тэгээд гурав буудуулж байж үхнэ гэдэг дэлт саарлаас өөр араатанд байж үл болох хүчин чадал гэж санахад Бор ямаршуу араатан унагаснаа сая ухаарах шиг болов. Хаагаа тас буудуулсан мөртөө харин ч хөл орсон мэт өмнөх хад бартааг давж, самбаа муутайхан анчинтай таарсан бол тасчин хаяж ч мэдэх ийм араншин чоноос өөр араатанд байж тааршгүй гэж санахад чоно хэмээгч нь ямар аюултай араатан болох нь бүр тодорхой ажээ. Ан гөрөөс үхэн үхлээ хүнээс зугтана. Араатан дайсан бол үхэн үхлээ хүнтэй тэмцэлдэнэ гэдэг үнэн ажээ.

Бор, дэлт саарлын хавхыг салгав. Цагт дөчөөд км давхих чадалтай түүний хөлийг хавх ёстой бахь шиг зуужээ. Бор хоёр чихнээс нь зуурч чирч хадан дээр гаргах гэж нилээд зүдрэв. Хоргодож хэвтсэн их хар модны тэнд хөлнийхөө тасархайтай цуг хаясан хавхы нь олж ирэв.

Морь л лав гэрт хүрсэн гэж тэр бодов.

Хангайн нутгийн олон чонын хаан байсан дэлт саарал хэмээгдсэн сүүлчийн том чоныг Хангайн Бор хэмээх хүү ингэж унагасан юм гэнэ лээ!

*Улаанбаатар*

*1970 он*